



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-12
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	13-55

<i>1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	13-55
---	-------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 18-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 42 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Х.Баттулга, Б.Заяабал, М.Нарантуяа-Нара, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж;

Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн Я.Цэлмэн, Улсын Ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, мөн ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Д.Мөнхөө, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, мөн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн З.Сүхбаатар, тус холбооны Мэргэшлийн хорооны дарга Д.Батсүх, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Нийслэлийн өмгөөлөгчийн зөвлөлийн дарга Т.Энхбаяр, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга С.Түмэн-Од, мөн газрын Мөрдөн шалгах газрын тасгийн дарга В.Баасанхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга П.Оростогоо, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Д.Сандаг, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга Б.Батдэлгэр, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Б.Батзориг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Н.Ариунболд, зөвлөх Д.Батмөнх, Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн Ч.Өнөржаргал, Монголын криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Х.Баасанжаргал, М.Нарантуяа-Нара, У.Отгонбаяр, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин, Да.Цогтбаатар /“цаашид ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн	11
Татгалзсан	3
Бүгд	14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналын томъёололтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Л.Соронзонболд, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров нар хариулж, тайлбар хийв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 5 дахь хэсгийн “бүх материалтай биечлэн, эсхүл цахимаар” гэснийг “материалтай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн	11
Татгалзсан	3
Бүгд	14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн	10
Татгалзсан	4

Бүгд 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.Мөрдөгч нь хэргийн оролцогчийн хүсэлтээр төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, төрийн үйлчилгээний нэгдсэн системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, хаяг, харилцаа холбооны утасны дугаарыг ашиглан дуудаж, прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болно” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11
Татгалзсан 3
Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14 дэх хэсгийн “шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11
Татгалзсан 3
Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 5 дахь хэсгийн “гомдлыг” гэсний дараа “энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11
Татгалзсан 3
Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн санал дэмжигдсэн тул дээрх саналтай холбогдуулан гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.Хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг хянан шийдвэрлэсэн дээд шатын прокурорын шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдлыг шүүх хянан шийдвэрлэх бөгөөд шүүхийн шийдвэрт гомдол гаргах, шийдвэрлэхэд энэ хуулийн 15.8-д заасныг баримтална.” гэсэн саналыг уншиж танилцуулж, санал хураалт явуулаагүй болно.

Д.Цогтбаатар: 7.Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12/16.14 дүгээр зүйлийн 5, 6, 7, 8, 9 дэх хэсэг:

“5.Эд мөрийн баримтыг бэхжүүлэхдээ тэдгээрийг хэн, хэзээ, ямар эх сурвалжаас хэрхэн олж авсан талаар, түүний онцлог шинж, хэлбэр дүрс, тоо хэмжээ, хадгалсан, шилжүүлсэн, хүлээн авсан шилжилт хөдөлгөөний талаар мөрдөн шалгах ажиллагааны болон прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгана.

6.Цахим баримтыг бэхжүүлэхдээ цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх явцад мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар авсан арга хэмжээ, хэрэглэсэн техник хэрэгслийг бэхжүүлсэн тэмдэглэл үйлдэж, гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээр давхар баталгаажуулна.

7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан ажиллагаанд оролцсон тусгай мэдлэгтэй мөрдөгч, мэргэжилтний хийсэн үйлдэл, үйл ажиллагааны нөхцөл байдал, авсан арга хэмжээ, ажиллагааны үр дүнг тэмдэглэлд бүрэн тусгана.

8.Цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгасан мэдээллийг сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцож болно.

9.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт хадгална” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	10
Татгалзсан	4
Бүгд	14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 8 дахь хэсгийн “зохих” гэснийг, мөн хэсгийн “тухай бүр” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	9
Татгалзсан	5
Бүгд	14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 17 дахь заалтын 3 дахь хэсгийн “оруулж, яллагдагчаар татах тогтоолд оруулсан өөрчлөлтийг” гэснийг “оруулсан тогтоолыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	10
Татгалзсан	4
Бүгд	14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалтын 9 дэх хэсгийн “хамаарахаас бусад хэсгийг” гэснийг “хамаарах хэсгийг нууцлан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	10
Татгалзсан	4
Бүгд	14

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	8
Татгалзсан	6
Бүгд	14

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 20 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	9
Татгалзсан	5
Бүгд	14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 34.16 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн бичгээр өгсөн тайлбарыг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал уншиж танилцуулав.

Зөвшөөрсөн	2
Татгалзсан	12
Бүгд	14

14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24/36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид бүрэн танилцуулж, төрийн нууцад хамаарах хэсгийг нууцлан гардуулан өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	6
Татгалзсан	8
Бүгд	14

42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: 15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 2.4 дэх заалтын “бусад баримтыг” гэсний дараа “энэ хуульд заасан журмын дагуу” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	6
Татгалзсан	8
Бүгд	14

42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	11
Татгалзсан	3
Бүгд	14

78.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: 15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 2.4 дэх заалтын “бусад баримтыг” гэсний дараа “энэ хуульд заасан журмын дагуу” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн	11
Татгалзсан	3
Бүгд	14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн санал дэмжигдсэн тул Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 5.1 дүгээр зүйлийн 5.4 дэх заалтын оролцох гэсний дараа, Шүүх шинжилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдийн өөрийнх нь зөвшөөрснөөр шинжилгээ хийлгэх гэж нэмэх гэсэн санал гаргасныг уншиж танилцуулж, санал хураалт явуулаагүй болно.

Д.Цогтбаатар: 16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтын 1.8 дахь заалтын “биечлэн, эсхүл цахимаар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	9
------------	---

Татгалзсан 3
Бүгд 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалтын 2 дахь хэсгийн “,эсхүл цахим хэлбэрээр” гэснийг хасаж мөн заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогч хэргийн материалтай ажлын 3-аас доошгүй өдрийн хугацаанд танилцах ба мөрдөгч хэргийн материалтай танилцах боломж, нөхцөлөөр хангана. Хавтаст хэргийн материал танилцуулах үндсэн хугацаа 14 хүртэл хоног байх бөгөөд хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан тус хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11
Татгалзсан 3
Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров нар хариулж, тайлбар хийв.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалтын 8 дахь хэсгийн “хавсаргуулна” гэснийг “хавсаргаж болно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11
Татгалзсан 3
Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 15 дахь заалтын 9 дэх хэсгийн “оролцогч” гэсний дараа “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11
Татгалзсан 3
Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “34.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “төлөөлж болно” гэснийг “төлөөлнө” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11
Татгалзсан 3

Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлж, тайлбар хийв.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Д.Цогтбаатар: 21.Төслийн 5 дугаар зүйлийн “16.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар” гэснийг,” гэснийг хасаж, 16.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дугаар зүйлийн 10 дахь заалт болгох.

“10/16.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Ажлын хэсгийн гаргасан, Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж тайлбар, мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан тайлбар, мэдүүлэг, бусад нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй бөгөөд тайлбар мэдүүлэг өгсөн хэрэгт нь тухайн хүнийг яллах талын нотлох эх сурвалж болгохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 7
Татгалзсан 7
Бүгд 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал дээр Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин цөөнх болов.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 10
Татгалзсан 4
Бүгд 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан найруулгын саналаар санал хураалт явуулав.

Найруулгын санал

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн, 3 дугаар зүйлийн “зүйл,” гэснийг тус тус хасаж, 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 8 дахь хэсгийн “заасны” гэснийг “заасан журмын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11

Татгалзсан 3
Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “шинжээч” гэсний дараа “сэжигтэн,” гэж” гэснийг “12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11
Татгалзсан 3
Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын “2.12” гэснийг “2.13” гэж, мөн зүйлийн 7 дахь заалтын “5” гэснийг “6” гэж, мөн зүйлийн 13 дахь заалтын 6 дахь хэсгийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11
Татгалзсан 3
Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “2.12, 2.13, 2.14, 2.15, 2.16, 2.17” гэснийг “2.11, 2.12, 2.13, 2.14, 2.15, 2.16” гэж, мөн зүйлийн “31.2 дугаар зүйлийн гарчгийг” гэснийг “31.2 дугаар зүйлийн гарчгийн “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа хийгдэх ажиллагаа” гэснийг” гэж, мөн зүйлийн “31.3 дугаар зүйлийн гарчгийг” гэснийг “31.3 дугаар зүйлийн гарчгийн “Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах” гэснийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11
Татгалзсан 3
Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Хоёр.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 11
Татгалзсан 3
Бүгд 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 20 гишүүн 2025.05.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар оролцов.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар уг асуудлыг дахин ярилцах шаардлагатай гэж үзэж санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 16 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Нямбаяр Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, П.Сайнзориг, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Н.Алтанхуяг, Г.Уянгахишиг, П.Сайнзориг нар ажиллахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 40 минут үргэлжилж, 22 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 81.8 хувийн ирцтэйгээр 16 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхимд 13 цаг 42 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаа эхлүүлье.

Хүрэлцэн ирсэн гишүүддээ талархал илэрхийлж, энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны энэ өдрийн хуралдаанаа нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Ирц Дамдины Цогтбаатар, Хүрэлбаатарын Баасанжаргал, Дашдондогийн Ганбат, Одсүрэнгийн Номинчимэг, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн ийм ирцтэйгээр ирц бүрдсэн байна. Ирц 54.5 хувь байна. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 3 асуудал бид нар хэлэлцэхээр байж байгаа.

Нэгдүгээр асуудал. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.

Хоёрдугаар асуудал. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин нараас 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх.

Гуравдугаар асуудал. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм 3 асуудал байгаа.

Тэгээд ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал санал нэрээ өгнө үү? Алга байна. Тэгвэл ингээд хэлэлцэх асуудлыг баталлаа.

Тэгээд хэлэлцэх асуудалдаа орьё.

Нэгдүгээр асуудал. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг танилцуулна. Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Ажлын хэсэг орж ирээрэй.

П.Сайнзориг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2025 оны 5 дугаар тогтоолоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Х.Баасанжаргал, М.Нарантуяа-Нара, У.Отгонбаяр, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар нар ажиллаж байна аа.

Ажлын хэсэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлгийг зохион байгуулж, хуулийн төсөлд туссан зарим асуудал шинжлэх ухааны болон онол практикийн түвшинд нарийвчлан судалж, холбогдох харьцуулсан судалгаа, лавлагаа, мэдээлэл болон төсөлд ирүүлсэн саналтай танилцсан.

Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, хуулийн төсөлд тусгасан асуудлыг асуудал бүрийг нэг бүрчлэн хэлэлцэн, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний үндсэн эрхийг хангах зорилгоор дараах асуудлыг Байнгын хороонд танилцуулж байна аа.

Нэг. Дуудан ирүүлэхтэй холбоотой зохицуулалтын талаар. Мөрдөгч нь хэргийн оролцогчийн хүсэлтээр төрийн байгууллага, албан тушаалтны алба, албаны цахим шуудан, албан бичиг, солилцооны дундын систем, төрийн үйлчилгээний нэгдсэн системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, хаяг, харилцаа холбооны утасны дугаарыг ашиглан дуудаж прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болох зохицуулалтыг тусгах.

Нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх зохицуулалтын талаар. Мөрдөн шалгах ажиллагааны болон прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд нотлох баримтыг бэхжүүлэхдээ тэдгээрийн хэн, хэзээ, ямар эх сурвалжаас хэрхэн, олж авсан талаар мөн түүний онцлог шинж, хэлбэр дүрс, тоо хэмжээ, хадгалсан, шилжүүлсэн, хүлээн авсан

шилжилт хөдөлгөөний талаар тус тус тусгах. Цахим баримтыг бэхжүүлэхдээ цуглуулах, хадгалах, зөөвөрлөх явцад мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажилласан талаар, хэрэглэсэн техник хэрэгслийн талаар тэмдэглэл хөтөлж, гэрэл зураг, дуу, дууны дүрсний дуу-дүрсний бичлэгээр давхар баталгаажуулах зохицуулалтыг тодруулан тусгах.

Мөн цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгасан мэдээллийг сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцож болох зохицуулалтыг тусгах. Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах зохицуулалтын талаар Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тусгасан. Уг зохицуулалттай холбоотойгоор мөрдөгч гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг эрүүгийн хэргийг хүлээж авч мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоогдсон нөхцөл байдлыг үнэлж, хуульд заасны дагуу хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлсэн хэргийн материалтай прокурор 14 хоногийн дотор хянах, зайлшгүй тохиолдолд дээд шатны прокурор энэ хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болох зохицуулалтыг тодруулан тусгалаа.

Шүүгдэгч шүүх хуралдаанд оролцох зохицуулалтын талаар тодорхой асуудлуудыг бас хөндлөө. Шүүгдэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгааг хангах хүрээнд тодорхой шалтгааны улмаас шүүгдэгчийн эзгүйд шүүх хуралдаан явуулж, түүний гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэхээр туссан байсан зохицуулалтыг төслөөс хасах саналыг Байнгын хороонд танилцуулж байна аа.

Шүүхийн шийдвэрийг гардуулан өгөх зохицуулалтын талаар бас тодорхой саналыг тусгаж оруулж ирж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 13 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 40.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн зохицуулалттай уялдуулан төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор оролцогчид бүрэн танилцуулж, төрийн нууцад хамаарах эсэхийг нууцлан гардуулж өгөх зохицуулалтыг тодруулан тусгалаа.

Өмгөөлөгчийн эрх үүргийн талаар энэ хуулийн бас тодорхой үзэл баримтлалд тусгаж орж ирсэн. Уг зохицуулалттай холбоотойгоор мөрдөгч прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах, хэргийг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг нотлох чиг үүргээ хэрэгжүүлээгүй бол яллагдагч шүүгдэгч энэ талаарх нотлох баримтыг энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд гаргаж өгөхтэй байх зохицуулалтыг мөн тусгаж байна аа. Хавтаст хэргийн материалтай танилцуулах зохицуулалтуудыг тодруулж, шүүхийн хэлэлцүүлгийг талуудын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явуулах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд мөрдөгч оролцогчийн хэргийн материалтай танилцах боломж нөхцөлөөр хангах, оролцогчийн хэргийн материалтай танилцах ажлыг 3-аас доошгүй өдрийн хугацаанд одоо танилцах боломжийг олгох, мөн хавтаст хэргийн материалын танилцуулах үндсэн хугацаа 14 хүртэл хоног байх, хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан мөн хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болох зохицуулалтыг тусгалаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай шийдвэрлэх ажиллагаанд оролцогч адил тэгш эрх, үүрэгтэй байх боломжийг хангах хүрээнд өмгөөлөгчийг хэрэг өмгөөлөгч хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнө нотлох баримтыг хэрэгт хавсаргаж

болох тодорхой мэдээлэл баримтыг хэрэгт хавсаргаж болох зохицуулалтыг тодрууллаа. Түүнчлэн өмгөөлөгч шүүх хуралдаанд орох зохицуулалтыг илүү их сайжруулж орох оролдлогыг бас ажлын хэсгээр нэг бүрчлэн ярилцаж, хүнийг шударгаар шүүлгэх эрхийг хангах, хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэх үүднээс шүүгдэгчийг хэд хэдэн өмгөөлөгч өмгөөлж байгаа бол шүүх хуралдаан тодорхой асуудлаар мэтгэлцэх, нэг өмгөөлөгч бусдыгаа төлөөлж болох зохицуулалтыг хуульд одоо хасах зохицуулалтыг орууллаа.

Эрүүгийн шүүлт тулгаж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байх зохицуулалтыг тодруулж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмыг бүрдүүлэхэд тодорхой саналыг бас танилцуулж байна аа. Эрүү шүүлт тулгаж бусдыг, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж, тайлбар мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан тайлбар мэдүүлэг бусад нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй бөгөөд тайлбар мэдүүлэг өгсөн хэрэгт тухайн хүнийг яллах талын нотлох эх сурвалж болгохгүй байх тодруулсан зохицуулалтыг санал хураалгахаар бас та бүгдэд танилцуулж байна аа.

Хавтаст хэргийг цахимжуулах цахим суурьтай нотлох баримтыг шүүх хуралдаан шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмын зохицуулалтыг одоо тусгаж орж ирсэн бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсвэл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах солилцох боломжтой мэдээллийг хүн хуулийн этгээд шаардахгүй байх. Хүн, хуулийн этгээд нь төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр харилцах боломж олгосон зохицуулалт нь Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хууль, Шүүхийн тухай хуульд тусгагдсан хэдий ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангаж, уг ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх үүднээс эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн хавтаст хэргийг цахимжуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч байгууллагуудын цахим мэдээллийн санг нэгтгэн холбох, цахим системийн ашиглалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг нэгдсэн байдлаар зохицуулж, процессын нэгдмэл журам, нэг платформ шилжүүлэх шаардлага үүсэж байх тул хавтаст хэргийг цахимжуулах, цахим суурьтай нотлох баримтыг Шүүх хуралдаан шинжлэн судлах, цахим суурьтай нотлох баримтыг үнэлэх журмын зохицуулалтыг энэ удаагийн төслөөс хасах саналыг оруулж байна аа.

Ажлын хэсэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналыг бэлтгэн томъёолж та бүгдэд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Б.Энхболд, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн Я.Цэлмэн, Улсын прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар дарга ирсэн байна. Батцэрэн шүүгч, Энхболд дарга хоёр бол байхгүй байгаа юм байна шүү. Байгаа юу? Тийм байхгүй байгаа юм байна гэж би ойлголоо. Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга С.Түмэн-Од, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын тасгийн дарга В.Баасанхүү, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга Х.Буянтүмэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга хурандаа П.Оростогоо, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа Б.Батзориг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Д.Сандаг, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа П.Очбадрах, Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга Б.Батдэлгэр, Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн З.Сүхбаатар, Монголын криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Батзориг, Монголын өмгөөлөгчдийн холбооны мэргэжлийн холбооны дарга Д.Батсүх, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Нийслэлийн Өмгөөлөгчийн зөвлөлийн дарга Т.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг энэ хуралдаанд оролцож байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс 12, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэгээс 1, Жаргалангаас 1 зарчмын зөрүүтэй санал тус тус ирүүлсэн байна аа. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Энхбаяр гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Нэгдүгээрт, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Дээд шүүхийн төлөөлөл орж ажилласан уу, саналыг нь авсан уу? Энэ зарчмын зөрүүтэй саналууд дээр Улсын Дээд шүүхийн саналыг авсан уу? Шүүхийн хуульд зааснаар бас бол заавал саналыг нь бас авч явж байх учиртай. Тэр дотор ажлын дэд хэсгийн хүрээнд прокурор болон мөрдөх өмгөөллийн байгууллагын хүрээнд зарчмын саналын ойлголцолд хүрч чадаагүй саналын зөрүүтэй ийм байр сууриуд энэ 1 дүгээр зүйлтэй холбоотой байгаа юу гэдгийг прокурор, Хууль зүйн яам, өмгөөллийн байгууллага болон мөрдөх байгууллагуудын төлөөллөөс асууж байна.

Гуравдугаарт ажлын хэсгээс боловсруулсан 1 дүгээр зүйлд байгаа одоо бидний 13 дахь саналын томъёололд байгаа төрийн нууцад хамаарах мэдээлэл

агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор оролцогчид бүрэн танилцуулж, энэ бол Засгийн газраас өргөн барьсан төсөлд байгаа заалт. Энийг яаж өөрчилж байна вэ гэхээр би энэ 2 дахь өгүүлбэрийг нь өөрчилж байгаа юм байна гэж ойлголоо.

Төрийн нууцад хамаарах эсэхийг нууцлан гардуулна гэж. За энийг юу гэж ойлгож байгаа юм бэ? Одоо бол төрийн нууцад хамаарах эсэхийг тэр хэргийн оролцогчид өгчих юм байна гэж би ойлгож байна мөн үү? Нууцалж гардуулна гэдгийг юу гэсэн үг юм? Нууцлалыг нь хадгалуулна гэж байгаа юм уу, эсвэл нууц алдагдахгүй байр саванд танилцуулахыг хэлээд байна уу? Бүүр өгөхийг хэлээд байна уу? Төрийн нууц нь бичигдчихсэн шүүхийн шийдвэр байгаа шүү дээ. Бүүр өгчихийг хэлээд байна уу?

10-аад жилийн өмнө шиг санаж байна. Манай нэг Засгийн газрын гишүүн төрийн маш нууцын зэрэгтэй шүүхийн шийдвэрийг шууд нэвтрүүлэгт оролцох үеэрээ гаргачаж байсан. Тэр дотор нь манай тагнуулын байгууллагын нууц ажилтны нэр бичигдчихсэн нь харагдаж байсан. Тэр шүүхийн шийдвэр дотор манай одоо тагнуулын байгууллагын маш нууц ажилтны нэрийг гаргачихсан, ил болгочихсон, улмаар тэр ажилтны амь нас, эрүүл мэнд, ар гэрийн байдал онц аюултай эрсдэлд орж байсан асуудал гарч байсан. Тэгэхээр энэ шүүхийн шийдвэрийн нууцлан гардуулан өгнө гэдгийг юу гэж ойлгож байгаа юм бэ? Тэрийг бүрмөсөн өгөөд тэр шүүхийн шийдвэрээ аваад гэртээ хадгалаад байхыг хэлээд байгаа юм уу? Буцааж өгөхийг хэлээд байгаа юм уу танилцчихаад. Энийг яг юу гэж ойлгож ажлын хэсэг оруулж ирж байгаа юм бэ гэсэн асуулт байна.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Энхбаяр гишүүний 2 асуултад би хариулъя. Нэгдүгээрт, Улсын дээд шүүхээс бас Засгийн газраас өргөн барих шатандаа бол бас тодорхой саналуудыг авч, Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр байдаг байнгын ажлын хэсгээр хэлэлцүүлсэн гэж одоо бас ойлгож байгаа. Мөн бас бид нар Хууль зүйн байнгын хороон дээрээ байгуулагдсан ажлын хэсгийн хүрээндээ Улсын дээд шүүхийн төлөөллийг бас албан ёсоор одоо харилцаж, бичиг явуулж, яг албан ёсны нэрийг нь авч бас оролцуулж бас энэ тодорхой саналууд дээр бас санал байр сууриудыг нь сонссон гэдэг зүйлийг бас танд хэлье.

Хоёрдугаар асуулт ажлын хэсэг дэд хэсгээс хариулах байх. Гуравдах асуултын хувьд бол энэ төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтыг бид нар бол өөрчлөн найруулж орж ирж байгаа. За 24 дүгээр зүйл дээр энэ төрийн нууцад хамаарах мэдээллийг агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор оролцогчид бүрэн танилцуулж асуудал байгаа. Энэ хэсэг бол агуулгын хувьд өөрчлөгдөөгүй боловч орж ирсэн төсөл дээр тэр хэсгийг хасаж, хэвлэн прокурор оролцогчид гардуулна аа гэсэн үг байсан юм. Тэр хэсгийг хасна. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол яллах дүгнэлтийг одоо тэнд төрийн нууцад хамаарах юм бол яллах дүгнэлтийг бүрэн танилцуулчихаад яг цаасаар өгч байгаа буюу гардуулан өгөх хэсэг дээрээ болохоороо одоо делет хийж гардуулах асуудал байдаг.

Практик дээр бас зүгээр гэдэг юм уу, амьдрал дээр юу байдаг гэхээр яллах дүгнэлт нь буюу хавтаст хэрэгт байгаа нь ийм зузаан байгаад байдаг. Яг нөгөө хэргийн оролцогчид гардаж авсан материал нь бол ийм нимгэхэн зүйл ч байдаг юм уу, намайг ерөөсөө ийм зүйлээр яллаж байгаа юм ч гэдэг юм уу сүүлд ингээд бас энийг янз бүрийн байдлаар ашигладаг тохиолдол байдаг. Тэгэхээр бид хэд энийг юу вэ гэхээр ер нь зүгээр яах вэ яллах дүгнэлтийн хэмжээ одоо янз бүрийн байдал бол

агуулга ерөөсөө өөрчлөгдөж болохгүй. Тийм учраас техникийн хувьд энийг нууцлан буюу одоо энэ программ хангамжийн хувьд угаасаа ингээд тэр бичвэр текстийг дараад харлуулаад өгчих бололцоо байдаг юм байна.

Тэгэхээр үндсэндээ яг ямар хэрэгт яллаж, энэ яллах дүгнэлтийг өгсөн тэрний үндэслэлүүд мэдээж бүрэн танилцуулахаасаа гадна тэр өгч байгаа тэр яллах дүгнэлтийн тоо, хуудасны хэмжээ ерөөсөө зөрөхгүй ээ л гэсэн ийм бас давхар агуулгаар бас өгч байгаа. Тэрнээс биш яг таны хэлж байгаа шиг төрийн нууцыг одоо хадгалаарай ч гэдэг юм уу, шууд төрийн нууцыг өгчхөж байгаа зүйл бол байхгүй байгаа. Хасаж өгөөд дараа нь ингээд надад байгаа нь ийм цөөхөн хуудастай хавтаст хэрэгт байгаа нь тэр гээд эсвэл ингээд баахан зохиомлоор юм оруулчихлаа, нэмчихлээ ч гэдэг юм уу ийм агуулгууд бас зүгээр практикийн хүрээнд гараад байдаг. Энэнээс бид нар урьдчилан сэргийлээд, техникийн шийдлийн хувьд бол угаасаа ингээд дараад текстийг унших бололцоогүй байдлаар ингээд гардуулж өгөх бололцоо байгаа учраас ийм байдлаар өгчхөөч ээ гэдэг одоо агуулгаар бид хэд энэ томъёоллыг оруулж ирж байгаа юм аа.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс 2 дугаар асуудал, асуулт байсан байх тиймээ. 2 дугаар микрофоныг өгье.

Н.Жамъянхүү: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яам Жамъянхүү. Улсын дээд шүүхээс 2024 оны 11 сарын 1-ний өдөр болбол энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр албан ёсоор бичгийн саналыг авсан. Мөн энэ хуулийн төслийг болбол Хууль зүй, дотоод хэргийн яаман дээрх байнгын ажиллагаатай ажлын хэсгээр болбол мөн хэлэлцүүлсэн. Энэ ажлын хэсэгт бол Улсын дээд шүүхийн шүүгч Батцэрэн шүүгч өөрөө оролцдог.

Албан бичгээр авсан санал дээр болбол Улсын дээд шүүхээс болбол энэ төрийн нууцад хамаарахтай холбоотой энэ шүүх хэсгийг бол шүүхийн шийдвэртэй нь хамт гардуулж өгөх гэсэн ийм саналыг ирүүлж байсан. Гэхдээ сая Улсын Их Хурал дээр байгуулагдсан дэд ажлын хэсэг дотор болбол манай Улсын дээд шүүхийн Батцэрэн шүүгч оролцсон. Энэ оролцож бид нар хэлэлцэхдээ болбол одоо зарим шүүх төрийн нууцтай холбоотой шүүхийн шийдвэрийг гардуулж өгөхөд нь одоо харлуулах байдлаар одоо яг тодорхой төрийн нууцтай хэсгийг харлуулж, техникийн ийм шийдлийг ашиглах байдлаар ингэж гардуулж өгье. 2 Шүүхийн шийдвэрийг тус тусдаа өгөхгүй байдлаар.

Мөн энэнтэй ялгаагүй бас энэ яллах дүгнэлт болбол мөн адилхан бас яригдаж байгаа. Энэ дээр бол яллах дүгнэлт дээр орсон төрийн нууцтай холбоотой хэсгийг болбол мөн адилхан. Техникийн шийдлийн хүрээнд болбол энэ харлуулах байдлаар харлуулаад ингээд оролцогч нарт гардуулж өгөх гэсэн ийм томъёоллоор болбол дэд ажлын хэсэг бол санал хураагаад дэмжээд ингээд том ажлын хэсгээр хэлэлцсэн байгаа.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье, тодруулъя.

Б.Энхбаяр: Би бол Засгийн газраас өргөн барьсан төслийн хувилбарыг нь яг энэ төрийн нууцад хамаарах хэсгийн тухайтад бол дэмжинэ. Төрийн нууцад хамаарах эсэхийг нууцлан гардуулан өгнө гэдгийг бол ажлын хэсэг бол харлуулж байгаад гардуулж өгнө өө гэж тайлбарлаж байгаа юм байна тийм. Нууцлан гэдэг үгийг бол дээр нь хараар харагдахгүй болгож байгаад гэж тайлбарлаж байгаа юм

байна. За энийг протоколд одоо хатуу бичиж ойлгохгүй бол хууль хэрэглээн дээр дараа нь одоо нус нугалаа үүсэх вий гэсэн болгоомжлол бол байна. Уг нь дахиад...

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Тэгэхээр яах вэ Энхбаяр гишүүний бас нэг хууль хэрэглээний зөрүүтэй байдал ч юм уу, янз бүрийн юм буруу байдлаар ашиглагдах ч вий гэдэг болгоомжлолыг болбол ойлгож байгаа. Нууцлан гэдгийг бол бид нар бол техникийн шийдлээр харлуулах эсвэл яг энэ мэдээллийг харах боломжгүй байдлаар яг одоо өгөхийг л ойлгож байгаа. Яллах дүгнэлт болоод энэ шүүхийн шийдвэрийг. Энэ байдал бол яах вэ зүгээр би нөгөө түрүүн үр дагаврыг нь бол хэлсэн. Зарим зүйлүүд бол намайг ийм яллах дүгнэлтээр байгаагүй зүйлүүдийг тусгаж дараа нь орж ирсэн ч гэдэг юм уу. Ингээд энэ бас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бас магадгүй шүүх, энэ шударга ёсныд бас итгэх гэдэг юм уу, энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бас итгэх энэ итгэлийг бас үгүй хийчхэж байгаа ч юм шиг. Үнэхээр яг бодит байдал дээр зөрүүтэй юмнууд харагдаад байдаг. Тоо ширхэг нь зөрөөд байдаг байдлаасаа л бид нар ангижирч, энэ техникийн шийдлээрээ энэ асуудлыг өгчихье.

Тэгээд протоколын хувьд яг Энхбаяр гишүүн таны хэлж байгаагаар бид хэд бас ойлгож явах ёстой гэдэг зүйлийг бас...

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: За яах вэ би ер нь бол Хууль зүйн байнгын хороо бол Эрүүгийн болон Эрүүгийн процессын хуулийн ийм хэмжээний том өөрчлөлтийн асуудлаар ядаж нэг дотроо бүгдийг нь оролцуулж байгаад нэг хэлэлцүүлэг хийчихсэн бол их зүгээр байсан юм. Өөрөөр хэлбэл Улсын Дээд шүүх, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч гэсэн байгууллагуудаас гишүүд чөлөөтэй асуух асуултаа асуугаад, танин мэдэхүйн асуултаа үг нэр, томъёоны ойлголтоо авч байгаад Их Хурал руу оруулбал уг нь их зүгээр байгаа юм.

Би одоо энэ эрүүгийн процессын хуулийн өөрчлөлтийн талаар манай Байнгын хорооны гишүүд уншаад, их ойлгоц ойлгоод ярьж байгаа гэдэгт би итгэхгүй байна. Тэгээд энэ дээр алдаа гарвал аягүй эрсдэлтэй байдаг. Хөөн хэлэлцэх хугацаан дээр юу боллоо доо. Ганц үг өөрчлөөд...

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүнд микрофон өгье.

П.Сайнзориг: Яг одоо бид хэд бас холбогдох дэгийн хуулийн дагуу уг хууль дээр гишүүдийгээ бас чөлөөтэй оролцох байдалтай Хууль зүйн байнгын хорооноос стэйкхолдер байгууллага буюу ашиг сонирхол гэдэг юм уу энийг хэрэгжүүлэх, хэрэглэх байгууллагууд энэ бүгдийг оролцуулаад Байнгын хороо бол хэлэлцүүлэг хийсэн. Би одоо он сарыг нь бол шууд хэлж чадахгүй нь. Энэ чинь 5 сарын, 4 сарын сүүлээр, 5 сарын эхээр бол луу, ямар ч байсан хэлэлцүүлгийг бол хийж байж хэлэлцүүлэг дээр гарч ирсэн энэ саналуудыг ажлын хэсэг нэг бүрчлэн бас ярилцаж, ажлын дэд хэсэг бас хэдэн удаа хуралдсаныг мэдэхгүй байна. Бид хэд бас нэлээн олон удаа хуралдаж байж бас орж ирсэн шүү гэдэг зүйлийг бас би хэлмээр байна аа.

Д.Цогтбаатар: Соронзонболд гишүүн. Гэхдээ хэдүүлээ дэгээ барьж байна шүү би танд одоо энэ удаа өгчихье. Цаашдаа бол цагтаа яг өгч байгаарай саналаа. Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Би нөгөө ийм асуулт байгаад байгаа юм. Энэ практик шаардлага дээрээ энэ нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн практик шаардлага дээр болохоор цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах өөрчлөх, хүчингүй болгох, хугацаа сунгах эсэхийг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэгт өмгөөлөгчийн оролцоо, мэтгэлцэх зарчим туйлын хангалтгүй байна гэж өмгөөлөгчдийн 72 хувь нь дүгнэсэн байсан. Энийг одоо нэмэлт, өөрчлөлтөд яаж тусгаж оруулсан бэ гэдэг нэг асуулт. Энэ дээр харахаар юу ч харагдахгүй байгаад байгаа юм.

Мөн анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь өмгөөлөгчийн зүгээс нэмэлт нотлох баримт цуглуулахтай холбоотой хүсэлтийг хангалттай шийдвэрлэдэггүй асуудал байна аа гээд ийм практик шаардлага дээрээ бичсэн байсан л даа. Тэгэхээр эдгээр асуудлуудыг ер нь яаж одоо энэ 1 дүгээр зүйл дээрээ тусгасан бэ гэдэг 1 дүгээр асуулт байгаад байна.

Хоёрт нь болохоор бол энэ дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг тодорхой хугацаагаар хадгалах зохицуулалтыг энэ хууль дээр тодорхой болгооч ээ гэдэг ийм шаардлагатай байна аа гэдгийг практик шаардлага дээр бас тусгасан байсан. Энэ асуудал ер нь яаж нэмэлт, өөрчлөлтөд орж байгаа вэ гэсэн ийм 2 асуулт байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн, тэгээд Сайнзориг гишүүн ээ Баасанжаргал гишүүн ажлын хэсгийн гишүүний хувьд бас хариулт нэмье гэж байх шиг байна. Тэр боломжийг нь олгоно биз дээ. За Сайнзориг гишүүний микрофон.

П.Сайнзориг: Тийм манай ажлын дэд хэсэгт орсон гишүүдээс нэмж тайлбар одоо өгч бололгүй яах вэ. За 2 асуулт байна. Нэгдүгээрт яах вэ энэ удаагийн цахимжилттай холбоотой заалтуудыг би бас Алтангэрэл сайдтай тухайн үед одоо бид 2 зөвшилцөөд энэ удаагийн юман дээр бас хасчихъя аа. Тэгэхдээ бас зарим одоо хуучин зохицуулалтууд хэвээрээ үлдэж байгаа. Гол асуудал юу вэ гэхээрээ энэ Засгийн газар дээрээс нь шүүх эрх мэдлийн байгууллага, дээрээс нь нийтийн эрх зүйн статустай өмгөөлөх байгууллага ч гэдэг юм уу маш олон энэ оролцогч байгууллагуудын эрх ашиг, оролцоо өөрөө энэ цахимжилтын цаана яригдаад байгаа юмаа. Энэ дэд бүтцийг хэн цаашаа авч явах вэ. Энд асар их дата цуглана. Яг энэ цахимжилтын асуудал яваад ирэхээр.

Тэгэхээр хатуу болон зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэлтийг хэн цаашаа авч явах юм, аюулгүй байдлыг нь хэн цаашаа авч явах юм гэдэг зүйл яг эрүүгийн процессын хууль дээр бичигдэж болохгүй байгаа учраас энэ хэсгээ хасаад нэгдсэн нэг байдлаараа шүүх эрх мэдэл болон хууль сахиулах үйл ажиллагааны цахимжилтыг дэмжих ерөнхий хуулийг одоо намрын чуулганд өргөн барья. Ингээд энэ дэд бүтцээ хэн авч явах удирдлага зохион байгуулалт нь ойлгомжтой болох юм бол зөвхөн эрүүгийн эрх зүй хэрэг гэхгүйгээр цаашдаа захиргаа иргэний бүх хэргүүдээ хавтаст хэрэгтэй болгоход нэгдсэн нэг платформ буюу зардал мөнгөө хэдүүлээ одоо үр ашигтай гэдэг юм уу, үр дүнтэй байдлаар явъя аа гэдэг зүйлээр энэ шийдлийг олоод явсан. Засгийн газар дээр буюу Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр энэ ажлын хэсэг гарсан байгаа гэж би ойлгож байгаа. Хуучин ч гэсэн бас энэ чиглэлээр шүүх эрх мэдлийн байгууллагатай оролцоод явж байсан. Тэгэхгүй ингээд цахимжинаа гээд байдаг. Одоо хэний сервер дээр энэ датанууд цуглах гэдэг ч юм уу. Энэ дата мэдээллүүдийг хэн аюулгүй байдлыг нь хангах, энэ зүйлүүд ингээд одоогоор бол их

ойлгомжгүй байгаа. Ерөнхий байдалтай байгаа. Энийг л тодруулж байж дараа нь энэ асуудлаа явъя аа гэсэн нэг өнцөг гарч ирсэн.

Хоёрдугаарт яах вэ Өмгөөлөхийн тэр таны ярьж байгаа үзэл баримтлал дээр туссан мэдээллүүд энэ Засгийн газрын өргөн барьсан хууль дээрээ бас шийдлүүдтэй орж ирсэн. Өөрөөр хэлэх юм бол өмгөөлөх энэ бололцоог хангахаас эхлээд хавтаст хэрэгтэй танилцахаас, дээрээс нь хэргийг одоо яг боож дуусаад, шүүхийн урьдчилсан зүйлд шилжүүлэхээс эхлээд бас тодорхой үе шатууд дээр өмгөөлөгчийн оролцоонуудыг нэмэгдүүлж өгч байгаа. Дээрээс нь яах вэ өнөөдөр бас гол асуудал бол шүүх дээр тодорхой одоо нотлох баримтыг бас өмгөөлөгчийн зүгээс энэ хуульд заасан журмын дагуу гаргаж өгөх тэр бололцоог нь бол бүрдүүлж өгч байгаа. Хавтаст хэрэгтэй танилцах хугацаа мөрдөгч магадгүй нэгхэн цаг өгөөд, цагийн дараа бид нар шүүх рүү шилжүүлнэ ээ гэчихдэг байсан бол энэ удаад одоо хамгийн багадаа 72 цагийг өгнө.

Дээрээс нь хэргийн ээдрээ төвөгтэй байдал ч гэдэг юм уу тодорхой зайлшгүй энийг одоо асуудлуудад бас цаг хугацаа хэрэгтэй гэж үзэх юм бол энийг 14 хүртэл хоногоор сунгаад явах буюу энэ одоо хүмүүс маань хавтаст хэрэгтэйгээ бүрэн танилцаж байж үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалж бас мэтгэлцэх тэр бололцоог нь олгох зэрэг нэлээдгүй ийм олон зохицуулалтууд бас Засгийн газраас орж ирсэн. Энэ үндсэн санааг нь бид нар бас алдагдуулахгүйгээр бас тодруулж...

Д.Цогтбаатар: Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Тэгвэл одоо Өмгөөлөгчдийн холбоо энэ тал дээр энэ саналууд дээр ямар бодолтой байгаа юм бол? Яг одоо та бүхний тодорхой хэмжээнд тавьсан асуудлууд шийдэгдэж байна гэж харж байна уу?

Д.Цогтбаатар: Данзанноров даргын микрофон, 6 дугаар микрофон.

Л.Данзанноров: Өмгөөлөгчдийн холбоо Данзанноров. Энэ нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хүний эрхийг хангахтай эрх тэгш мэтгэлцээний нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой нэлээд чухал өөрчлөлтүүд орсон. Сая ажлын хэсгийн даргын хувьд бас нэлээд бас тодорхой тайлбарлалаа. Гишүүний яг тухайлж асуусан асуудал дээр нэмээд хэлэхэд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотой асуудалд өмнө нь одоо энэ хэлэлцүүлэг нь яаж явагддаг байсан бэ гэвэл прокуророос гаргасан зөвхөн саналтай л танилцдаг байсан бол одоо урьдчилаад энэ цагдан хорих үндэслэл болж байгаа ямар баримтууд байна. Тэдгээр баримтуудтай энэ урьдчилсан хэлэлцүүлэг, мөн таслан сэргийлэх арга хэмжээний хэлэлцүүлгийн өмнө өмгөөлөгчид заавал бүгд баримтуудтай нь биечлэн бүрэн танилцаж байж шүүхийн мэтгэлцээнд орох боломж бүрдсэн нь бол нэлээд давуу талтай нааштай өөрчлөлт гэж харж байгаа.

Д.Цогтбаатар: Болж байгаа гэж л хариулж байх шиг байна шүү дээ. За Баасанжаргал гишүүн нэмэлт тайлбар өгье. Ажлын хэсгийн гишүүний хувьд.

Х.Баасанжаргал: Түрүүн Энхбаяр гишүүний асуусан асуулт, сая Соронзонболд гишүүний асуусан асуулттай аль алинтай нь холбоотой нэг тайлбар өгөх нь зөв байх аа. Манай ажлын хэсэг яах вэ яг энэ хуулийн төсөл дээр нэг удаа хуралдаад бид нар зарим нэг зүйлүүд дээр бол санал бол нөгөө цөөнх болоод ингээд явчихсан заалтууд бас бол байгаа. Тэрийгээ бас манай өмгөөлөгчдийн холбоо. Яагаад гэвэл Энхбаяр гишүүн сая хамгийн эхэлж асуусан шүү дээ. Яг ингээд

нөгөө орж ирж байгаа энэ заалтуудтай өмгөөлөгчдийн холбоо, прокурор бүгд аль аль нь яг санал нэгтэй байгаа юм уу гэж асуусан тиймээ.

Тэгэхээр одоо жишээ нь 1 дүгээр зүйлийн 19 дүгээр зүйлийг энэ хасаж байгаатай бол Өмгөөлөгчдийн холбоо болбол санал нэгдээгүй, бас ажлын хэсгийн зарим гишүүд санал нэгдээгүй. Гэхдээ цөөнх болоод ингээд энэ бол хасагдаж байгаа заалт. Энийг одоо манай Өмгөөлөгчдийн холбоо болбол хэлэх ёстой гэж уг нь би хэлчхээсэй л гэж түрүүнээс хойш хараад л хүлээгээд байгаа. Тэгээд хэлэхгүй болохоор нь би өөрөө хэлж байна л даа. Энэ ямар учиртай юм гээд 19 дүгээр зүйл гээд харахаар 33.3 дугаар зүйлийн 1.4 дэх буюу хэргийн материал танилцуулах, хэргийн материал танилцуулж байгаатай холбоотой гарч байгаа бүх тэр процесс ажиллагаа бүрэн хэрвээ хийгээгүй байх юм бол хэргийг буцаана гэдэг заалт байсан юм. Энийг болбол хасаад яагаад гэвэл энэ болбол шаардлагагүй. Тэр 3 дээр байгаа мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн гэдэгт орчих учраас энэ болбол шаардлагагүй гээд хасаж байгаа юм.

Би бол хувьдаа энийг болбол хасах ёсгүй. Яагаад гэвэл энэ чинь яг нөгөө хэргийн материалыг прокуророос шүүхийн шатанд шилжүүлэхтэй холбоотой маш чухал ажиллагааны үе шат байхгүй юу. Тэгэхээр энэ дээр энэ нөгөө хэргийн материалыг бүрэн танилцуулах, материалтай холбоотой нотлох баримттай холбоотой ажиллагаа дээр гомдол санал гарах юм бол тэрийг шийдвэрлээгүй тохиолдолд хэргийг шүүх рүү шилжүүлсэн тохиолдолд буцаахыг болбол хүчингүй болгох энэ хэсгийг бол хасаж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ бол уг нь бол хэвээрээ үлдээмээр байсан боловч ажлын хэсэг дээр бол бид нар цөөнх болоод энэ заалт болбол хасагдаж байгаа гэдгийг зориуд би бас протоколд тэмдэглэж үлдээх гээд байгаа юм гэсэн үг.

Хоёрдугаарт Соронзонболд гишүүн асуусан. Түрүүн тэр нотлох баримттай танилцаад хуулбарлаж авахтай холбоотой...

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүн гүйцээгээд хариулъя.

Х.Баасанжаргал: Нотлох баримтыг хуулбарлаж авахтай холбоотой энэ нөгөө техник хэрэгсэл хуулийн төслийн 1.1 дээр орж ирж байгаа. Дуу дүрсний бичлэгийн болон бусад техник хэрэгсэл ашиглах гэдэг дээр энэ дээр бас нэмээд зүгээр гар утас гэдэг юм уу, гар утсыг яг ийм одоо энэ хуульд заасан зориулалтын дагуу ашиглах журмаар ашиглаж болохоор энэ дээр оруулж ирье ээ гэсэн боловч яах вэ нөгөө бусад техник хэрэгсэл гэдгээрээ орж байгаа гэдэг нэгдүгээр тайлбар явж байгаа.

Хоёрдугаарт, бас яг Сайнзориг гишүүний саяын уншсан тайлбар дээр болбол бас энийг бас тодотгож хэлж байгаа. Тэгэхээр зориуд нөгөө нэг протокол дээр тэмдэглэж үлдээхгүй бол одоо ялангуяа Авлигатай тэмцэх газар бол утас хураагаад оруулчихдаг шүү дээ. Тэгэхээр нөгөө нотлох баримтынхаа зургийг авъя. Эсвэл зориулалтын зургийн аппараттай орох ч гэдэг юм уу. Ингээд ийм хэрэгжилтийн явцад нугалаа гарч болзошгүй учраас бас энийг зориуд ингэж протоколд тэмдэглэж үлдээж байгаа шүү гэж хэлэх гэсэн юм.

Д.Цогтбаатар: Би нэг асуулт асуугаадахъя. Энэ юутай холбогдоод энэ нөгөө түрүүн нууцлан гардуулж өгнө үү гээд 24 дүгээр зүйл байсан уу тиймээ. Энэ дээр нэг юу нууцлан гардуулна гэдэг томьёо Монгол Улсын хуульд өөр газар хэрэглэгдэж

байгаа юу? Яг нууцлан гардуулна гэж яг юуг хэлээд тодорхойлчихсон байж байгаа юм. Энэний тодорхойлолт байгаа юу? Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Энэ асуудал бол яах вэ зүгээр бид хэд бол Тэмүүжин гишүүн энэ дээр бас нэлээн тийм том аргумент хэлсэн л дээ. Ер нь зүгээр яах вэ энэ төрийн нууцтай холбоотой асуудал дээр бүрэн танилцаж ер нь өөрсдөө авах ёстой гээд. Тэгэхээр өнөөдөр бид хэд Төрийн болон албаны нууцын тухай хууль нь хөндөгдөөгүй. Эргээд бусад заалтууд нь хөндөгдөж орж ирээгүй учраас энэ боломжгүй байгаа. Энэ нууц хадгалах этгээдийн асуудал дээр яг энэ хэргийн оролцогч байхгүй байгаа учраас бид нар энэ асуудлууд дээр дараа нь хуудасны зөрүүнээс гараад шүүх илүү дутуу гэдэг юм уу, мөрдөн байцаалтын шатанд илүү дутуу юм санаатайгаар хийчихсэн юм шиг энэ яриа хэлэлцээ гарч шүүх эрх мэдэл итгэх итгэл байдаг.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн ээ, миний асууж байгаа өөр газар яг ийм томьёо хэрэглэгдэж байгаа юу гэж байгаа байхгүй юу.

П.Сайнзориг: Тэгээд өөр газрын асуудал биш бид энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн асуудлыг ярьж байгаа. Тэгэхээр энэ хууль дээрээ нэгдмэл энэ ойлголтоор цаашдаа энэ техникийн бололцоо нь угаасаа байдаг юм байна. Бичиг хэргийн стандарт бүх юман дээрээ нууцалж энийг дарж өгөх бололцоо угаасаа байдаг. Одоо ч бид нар шүүх.мн рүү орох юм бол энэ шүүхийн шийдвэрүүдийг нууцлах гэдэг юм уу хүний хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой хэсгүүдийг нууцлаад ингээд оруулдаг энэ ойлголт практикийн хувьд тогтчихсон. Тэгэхээр энэ агуулгын хүрээнд бид нар төрийн нууцтай хэсгээ бол одоо нууцлах гэдэг юм уу яг практик дээр хэрэглэгдэж байгаа тэр яах вэ тэр ажлын дэд хэсгээс дараад гээд хэлчихлээ. Хараар дараад гээд. энэ агуулгаар нь орж байгаа юмаа Цогтбаатар дарга аа. Энэ бол практик дээр одоо хийгдээд явж байгаа буюу шүүх.мн дээр ороход энэ хувийн мэдээллүүд ингээд нууцлагдаж, дарагдаж ороод ингээд явж байгаа. Энэ практикаар нь бид нар оруулж байгаа юм аа.

Тэгэхээр энэ дээр хууль хэрэглээний нэгдмэл байдал дээр өөр зүйлээр ойлгож болохгүй шүү гээд Энхбаяр гишүүний хэлж байгаа зөв. Тэгэхдээ энийг зүгээр яах вэ практикийн хувьд, шийдлийн хувьд угаасаа тогтчихсон, хэрэглээд явж байгаа ойлголт юм байна лээ.

Д.Цогтбаатар: Тийм, энэ чинь одоо хууль тайлбарлахад хамгийн эхлээд шууд угаасаа текстээрээ тайлбарлаад явна шүү дээ. Тэгэхлээр энэ дээр чинь нэг ийм асуудал гараад байгаа байхгүй юу. Процессоо нууцалж байгаа. Тэр гардуулахыг нууцлах хэрэггүй байхгүй юу. Өгч байгаа материал чинь өөрөө нууц байгаад байгаа шүү дээ. Тэгээд тэрийгээ нууцална, харлуулахаа та нар нууцална гээд хэлчихсэн энэ томьёоллоо өөр хуульд нэгэнт байхгүй бол одоо энэ чинь энэ ойлголтоороо бэхжээд явах гэж байна шүү дээ. Тэгэхлээр энэ томьёоллоо та нар харахгүй бол гардуулахаа нууц өгөх нь чухал биш байхгүй юу. Тэгтэл энэ чинь тэгж уншигдаж байгаа байхгүй юу. Материал чинь өөрөө нууц байхгүй юу. Энэ цаад яригдаж байгаа нэг зүйл харин аягүй чухал. Яг үнэн. Энэ хохирогчид ялангуяа нууц гээд өөрт нь тэр танилцуулахгүй байх танилцуулж болох бүрэн хэмжээнд нь тэр танилцуулдаг байх ёстой. Нууцлах юмнуудаа мэдээж нууцлалгүй яах вэ.

Тэрэн дээрээ бол та нар юугаа бодоцгооно биз. Энэ томьёолол дээрээ харахгүй бол одоо энэ жишээлбэл, яг Англи дээр аягүй тодорхой байхгүй юу. Классифайди гэдэг бол мэдээллийн нууцлалыг хэлж байгаа юм. Классифайд Хэйнд

овер гэж байхгүй. Тэгтэл одоо секрет гэх юм уу коверт гэх юм уу тэр бол үйлдлийг хэлж байгаа юм нууцалж өгөх. Тэгэхлээр энэ дээр чинь нууцлаад байгаа чинь тэр бичиг баримтын агуулга байгаад байгаа байхгүй юу. Энийгээ та нар тодотгож өгөхгүй бол ёстой хэрэглээн дээр энэ үг, үсгээрээ л нууцлан гардуулна аа гээд нууц гардуулчихсаныгаа тэгж яриад ойлгоод явах уу гээд. Тэгэхлээр энийгээ та нар тэр томъёолол дээрээ сайн эргэж хараарай. Яагаад гэвэл өөр газар байхгүй юм байна шүү дээ. Энүүгээр л тогтох нь байна шүү дээ тэгэхлээр за тэгье. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Одоо текстийг дарга аа та яг бүтэн уншихгүй бол болохгүй ээ. Одоо жишээ нь Энхбаяр гишүүний эш татаад авч байгаа хэсэг дээр би уншъя л даа. Төрийн нууцад хамаарах мэдээллийг агуулсан яллах дүгнэлтийг яллагдагч бүрэн танилцуулж төрийн нууцад хамаарахаас бусад хэсгийг гардуулж өгнө үү гэдэг энэ анхны текст байж байгаа Засгийн газрын өргөн барьсан. Энэ дээр ямар байдлаар өөрчлөгдөж байгаа гэхээр төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан яллах дүгнэлтийг яллагдагчид бүрэн танилцуулж, нэгдүгээр одоо агуулга. Төрийн нууцад хамаарах хэсгийг гэж байгаа юм. Энэ өөрөө үг зүйн тайлбараараа найруулга талаасаа хэсгийг нууцална гэж байгаа юм. Энэ нөгөө өмнөх текстээ контекстэйгээ яахаар үйл үгээ тодотгосон асуудал биш байхгүй юу.

Тэгэхээр энэ текстийн хувьд бол бид нар одоо асуудал бол гарахгүй ээ гэж үзэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол төрийн нууцад хамаарах хэсгийг нууцлан тэгээд гардуулж өгнө өө гэдэг ойлголт яваа. Тэрнээс биш нууцад гардуулж өгч байгаа процессыг нууцлах гээд байгаа зүйл байхгүй байхгүй юу. Бүтэн текстээ үзвэл яг л энэ хэсгээ тэр хэсгийг нууцална аа гэж байгаа байхгүй юу. Ингэж бас ойлгоосой гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Харин би бүтэн хар аа. Бүтэн текстийг нь уншаад би ярьж байгаа. Наад дээр чинь одоо аливаа бичиг баримтын нэг хэсгээр энэ хуудас нь нууц байгаа байхгүй юу. Би энийг нь нууцлаад гардуулчихвал яах вэ гэдэг л асуудал яригдаж байна шүү дээ. Тэгэхлээр энийгээ би зөв, буруу гээгүй. Агуулга нь зөв байна. Томъёоллоо зөв болгохгүй бол наадах чинь хэрэглээн дээр асуудал гарна шүү л гэж байгаа. Түүнээс би текстээ бүрэн уншчихаад харин яриад байгаа байхгүй юу. Та нар бол харлуулна гээд өөртөө дотроо бодохдоо параграфын нэг хэсгийг харлуулах тухай. Хуудас байвал яах вэ. Жишээлбэл хүний зураг байвал нууц гэдэг чинь байна шүү дээ аягүй их юман дээр бид нар нэг агуу том юм бодоод байдаг байхгүй юу. Аягүй энгийн жижигхэн юм байдаг байхгүй юу. Тэр үхлүүт нууц гээд байгаа чинь зүгээр хүний нэр, утасны дугаар ч байж магадгүй.

Тэгэхлээр тэр юу чинь одоо хүний фото зураг фото идентификэйшн гэдэг чинь өөрөө аягүй нууц байж магадгүй байхгүй юу. Тэгэхлээр тэр юмыг одоо яах юм та нар нүүрийг нь бүтэн дарж өгнө гэх үү гээд энэ юм өнцгөөсөө л би бодоорой, тэрийгээ томъёоллоо тэгэхлээр тэгж буруу ойлгогдохгүйгээр нэг мөр нэгэнт энд орж байгаа бол хийгээрэй л гэж байхгүй юу. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Протоколд тэмдэглэж үлдээх гээд байгаа нөгөө би бол хувьдаа нууцлан гардуулж өгнө гэдгийг анх уншихдаа юу гэж уншсан бэ гэвэл гардуулж өгөхийн хувьд өгнө. Гэхдээ нууцын баталгаа юм уу, ямар нэгэн ийм, одоо баталгаа, ямар нэгэн тийм тэмдэг одоо юу байдаг юм тийм зүйл процесс, ажиллагаатайгаар нууцынхаа нууцын юмыг нь надад өгөх юм байна гэж би бол текстийг уншаад бол тэгж ойлгоод байна. Тэгэхээр би бүр Энхбаяр гишүүн, дарга хоёроос хоёр, та хоёроос би дахиад 3 дахь өөр ойлголт би эндээс гаргаж ирсэн байхгүй юу. Би бол ойлгохдоо тийм би болохлоор нууцлан гардуулна гэхээр нууц

материал байх юм байна. Тэгэхдээ надтай тэрийг нууцын баталгаа хийж байгаа тэгэхдээ надад өгөх юм байна гэж би бол хувьдаа тэгж ойлгосон.

Тэгэхээр харин бүүр ингээд тийм учраас би протоколд зориуд энийг тэмдэглүүлье гээд байгаа юм. Энэ эндээс чинь ингээд 3 өөр ойлголт гарч ирээд байгаа учраас зориуд тэмдэглүүлээд энийг ингэж ойлгох юм байна аа л гэж нэг мөр явах хэрэгтэй болчихоод байгаа байхгүй юу.

Д.Цогтбаатар: За тэгээд протоколд энэ нь үлдлээ. Ингээд хэдүүлээ цаашаа үргэлжлүүлээд явъя. Одоо ингээд санал хураалт руугаа оръё.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 5 дахь хэсгийн бүх материалтай биечлэн, эсхүл цахимаар гэснийг материалтай гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг хасах гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

71.4 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтын 9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

9 мөрдөгч нь хэргийн оролцогчийн хүсэлтээр төрийн байгууллага албан тушаалтны албаны цахим шуудан албан бичиг солилцооны дундын систем төрийн үйлчилгээний нэгдсэн системд иргэний үүсгэсэн бүр үүсгэсэн бүртгүүлсэн цахим шуудан, хаяг, харилцаа холбооны утсыг ашиглан дуудаж, прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болно гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүнийхээ уншиж танилцуулсан ажлын хэсгийн санал байсан.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 14 дэх хэсгийн шүүхийн шийдвэрийг цахим мэдээллийн сүлжээгээр гэснийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 5 дахь хэсгийн гомдлыг гэсний дараа энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд гэж нэмэх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэн учраас ажлын хэсгээс гаргасан санал дэмжигдлээ. Тийм учраас Жаргалан гишүүний гаргасан саналыг уншиж танилцуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 15.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

5 хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолын тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг хянан шийдвэрлэсэн дээд шатын прокурорын шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдлыг шүүх хянан шийдвэрлэх бөгөөд шүүхийн шийдвэрт гомдол гаргах, шийдвэрлэхэд энэ хуулийн 15.8-д заасныг баримтална.

Сая нөгөөдөх нь дэмжигдчихсэн болохлоор би зүгээр уншиж танилцуулж байгаа юм.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

12/16.14 дүгээр зүйлийн 5, 6, 7, 8, 9 дэх хэсэг:

5.Эд мөрийн баримтыг бэхжүүлэхдээ тэдгээрийг хэн, хэзээ, ямар эх сурвалжаас хэрхэн олж авсан талаар түүний онцлог шинж, хэлбэр дүрс, тоо хэмжээ, хадгалсан, шилжүүлсэн, хүлээн авсан шилжилт хөдөлгөөний талаар мөрдөн шалгах ажиллагааны болон прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгана.

6.Цахим баримтыг бэхжүүлэхдээ цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх явцад мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар авсан арга хэмжээ, хэрэглэсэн техник хэрэгслийг бэхжүүлсэн тэмдэглэл үйлдэж, гэрэл зураг авах дууны, дүрсний дүрсний дуу-дүрсний бичлэгээр давхар баталгаажуулна.

7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан ажиллагаанд оролцсон тусгай мэдлэгтэй мөрдөгч мэргэжилтний хийсэн үйлдэл үйл ажиллагааны нөхцөл байдал, авсан арга хэмжээ, ажиллагааны үр дүнг тэмдэглэлд бүрэн тусгана.

8.Цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгасан мэдээллийг сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцно тооцож болно.

9.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт хадгална гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

71.4 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 8 дахь хэсгийн зохих гэснийг мөн хэсгийн тухай бүр гэснийг тус тус хасах гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

63.3 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 17 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 17 дахь заалтын 3 дахь хэсгийн оруулж яллагдагчаар татах тогтоолд оруулсан өөрчлөлтийг гэснийг оруулсан тогтоолыг гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

74.1 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалтын 9 дэх хэсгийн хамаарахаас бусад хэсгийг гэснийг хамаарах хэсгийг нууцлан гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

74.1 хувиар санал. 71.4 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүн би нэлээн олон удаа ингээд хэлчихсэн үү, үгүй юу. Тэгвэл тэрийгээ та нар засаж дараа нь юундаа оруулаарай. 71.4 гэдгээ засаж хэлээрэй.

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 19 дэх заалтыг хасах гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.1 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 20 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 20 дахь заалтыг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.3 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгээс гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 34.16 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг. Санал хураалт. Санал хураалтыг түр зогсооё. Номинчимэг гишүүний тайлбарыг Баасанжаргал гишүүн уншиж танилцуулах нь байна. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Номинчимэг гишүүний зүгээс энэ нөгөө 8 дахь хэсгийг хасах гэдэг дээр зарчмын зөрүүтэй санал гаргасан. Эрүүгийн процессын хуулийн 5.2.7 дахь хэсэгт заасан энэ зохицуулалт болбол өөрөө Процессын хуулийн 5.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэг дээр заасан. Мөн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 34.16-гийн 8 дахь хэсэг дээр болбол тус тус одоо ингээд нэгэнт заачихсан байгаа асуудалтай агуулгын хувьд болбол давхцаж байна гэж ийм одоо үндэслэлээр болбол энэ саналыг болбол оруулж ирж байгаа юмаа. 52.7 дээр. Гаргаагүй, ажлын хэсгийн гишүүн биш байхгүй юу.

Д.Цогтбаатар: Дэгээр бол ажлын хэсгээс энэ дээр одоо ямар нэгэн тайлбар бол байхгүй байгаад байна. Харин тийм. Яг үнэн. Би харин тэрэн дээр сая Сайнзоригийг хэлэхлээр юм давхацчихаж байна гээд. Яах вэ миний бол зарчмын байр суурь ийм л байна л даа. Яг энэ дээр бол. Юм давхцаж байна гээд бид нар

хасах аягүй эрсдэлтэй. Тэрний оронд байж байсан нь дээр. Өөрөөр хэлбэл давхцаад л тэгвэл байж байна биз. Тэгэхгүй бол давхцаж байна гээд хасчихсан чинь тэнд аягүй нарийн нюанс хасагдчихсан байвал энэ чинь эргээд хэрэглэгдэхэд ёстой хүний эрх дээр асуудал гараад ирэх байхгүй юу. Тэгэхлээр ингэе. Санал хураалт руугаа ороод явчихъя. Дэгийн юунаас зөрчөөд яах вэ. За санал хураалт.

14.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

14.Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“24/36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид бүрэн танилцуулж, төрийн нууцад хамаарах хэсгийг нууцлан гардуулан өгнө гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

42.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

За ингэе. Сайнзориг гишүүн микрофоноо аваад үг хэлчих. Энэ дээр уг нь тийм дэг байхгүй шүү. Гэхдээ энэ жинхэнээсээ нарийн асуудал яригдаж байгаа учраас ялангуяа улсын нууцтай холбоотой асуудал яригдаж байгаа учраас Сайнзориг гишүүнд микрофоноо өг.

П.Сайнзориг: Энхбаяр гишүүний хэлж байгаа дээр бол агуулга яг адилхан байхгүй юу. Хасаж гэдэг нь магадгүй яллах дүгнэлтээс процессын хувьд байх ёстой мэдээллийг нь ч техникийн алдаа гаргаад хасаад өгчхөж магадгүй. Тэгэхээр яг яллах дүгнэлт дээр юу дурдаж байгаа, шүүхийн шийдвэр дээр юу дурдагдаж байгаа тэр хэсгээрээ одоо хэмжээ дамжаагаараа байж байх ёстой байхгүй юу. Яг программ бол хэчнээн программ мэдээлэл байсан яг түрүүгээрээ. Бид хэд харин тэр төрийн нууцтай хэсгийг нь дараад буюу техникийн шийдлээрээ одоо шүүхийн цахим мэдээллийн санд хийж байгаа арга зүйгээр явчих аа л гэдэг зүйлийг хэлж байгаа юм. Түүнээс биш энэ төрийн нууцыг өгөх гээд байгаа зүйл ерөөсөө байхгүй шүү дээ Энхбаяр гишүүн ээ.

Бид хэд өмнө нь яллах дүгнэлтээр бол ингэж өгч болно оо гэххээд шүүхийн шийдвэр дээр ингээд унагаачхаж байгаа юм. Тэгээд энэ дээр гишүүд маань бас бодно биз дээ. Би бол одоо агуулга яг адилхан байхгүй юу. Хасаж гэдэг чинь харин бүр эрсдэлтэй. Хасаж байна гэж байгаад дараа нь техникийн алдаа гаргаж өгчхөөд тэгсэн юм байна аа гээд аймаар үр дагавартай юм руу орох гээд. Бид нар болохоор хасахгүй яг хуудасны тоо хэвээрээ байна. Энэ нэгдүгээр программ бол төрийн нууц гэх юм бол энийг харин дарж өгөх ёстой тухай асуудал буюу ямар нэгэн хүнд одоо юу гэдэг юм үл ойлголцол гэдэг юм уу, дараа нь миний би гарт харж байна уу. Надад тавхан хуудас яллах дүгнэлтүүд шүүхийн шийдвэр байж байхад тэнд тэд гээд ингээд хуудасны зөрүү гаргаад ингэчихсэн байхгүй юу гээд ингээд практик дээр бас шүүхэд итгэх итгэл гэдэг юм уу ер нь энэ процессын үйл ажиллагаан дээр бас үл ойлголцлууд гараад байдгийг л засчихъя гэж байгаа юм.

Тэрнээс биш мэдээлэл өгөх гээд байгаа буюу зөрүүтэй агуулга ерөөсөө байхгүй шүү дээ. Хасаж гэдгийн цаана техникийн алдаа гарах магадлал улам ихсэж байгаа. Энэ дарна гэдэг бол бид хэд ном журмын дагуу төрийн нууцаа далдлаад л яг 5 хуудас яллах дүгнэлт байсан бол 5 хуудсаар нь, 5 хуудас шүүхийн шийдвэр байсан бол 5 хуудсаар нь л өгье гэж байгаа шүү дээ. Тэрнээс биш хасчхаад 2 хуудас өгөөд ингээд бас болохгүй л болчхоод байгаа юм л даа.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн ээ, энэ дээр ерөөсөө наадхыг чинь зөв, буруу гээгүй. Зүгээр энийгээ тодруулахгүй бол болохгүй нь гээд энэ дээр бас нэг юм тодруулж хэлэхгүй бол. Бид нарын түрүүн санал хураалт дээр энэ 10 дугаар зүйл дээр юу яачихсан байна шүү. Яг 10 дугаар санал хураалт дээр яг энэ агуулгатай юу ороод дэмжигдээд явчихсан байж байгаа. Тэгэхлээр одоо Их Хурал дээр ороод даргаас нөгөө гүйцээн боловсруулах чиглэл авч байгаа. Энэ дээрээ та нар өгье гүйцээгээд суугаад ажиллалчих. Өөрөөр хэлбэл илүү тодотгоод өгөх нь зөв байх гэж бодож байна. За ингээд цаашаа үргэлжлүүлээд явъя.

14.Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын. Сая би 14-ийг нь уншчихсан тиймээ. Энэ уначихсан тиймээ. 14 дүгээр санал чинь тэгэхлээр 42.9 хувиар санал дэмжигдсэнгүй. Ингээд төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? За байхгүй байна. Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс.

Зургаа Улсын Их Хурлын гишүүн Жаргалангаас 1 зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байгаа. Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. За Энхбаяр гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Төслийн 3 дугаар зүйл дээр өөрчлөн найруулах нэг санал орж ирж байгаа юм байна. Одоо энэ 16 дахь санал хураалт гэсэн үг. Биш ээ 20 дахь санал хураалт байна. Энэ эрүү шүүлт тулгаж бусад хэлбэрээр хүнлэг бус хэрцгий харьцаж тайлбар мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан тайлбар мэдүүлэг, бусад нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй бөгөөд тайлбар мэдүүлэг өгсөн хэрэгт нь тухайн хүнийг яллах талын нотлох эх сурвалж болгохгүй гэсэн ийм орж ирж байгаа юм байна. Энэ Засгийн газрын төсөл дээр 1 дүгээрт агуулга байсан уу, байсан болбол яаж өөрчилж байгаа юм. Эсвэл энийг ажлын хэсэг цоо шинээр оруулж ирж байгаа юм уу гэсэн эхний асуулт байна.

Хоёрдох асуулт нь хэрвээ ажлын хэсгээс энийг оруулж ирж байгаа болбол эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий харьцаж тайлбар мэдүүлэг авах бол гэмт хэрэг байгаа өөрөө. Энэ нь тогтоогдвол гэдэг нь энэ эрүү шүүлт тулгасан гэмт хэрэг нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсоныг яриад байна уу? Эсвэл тухайн хэрэг үйл явц шүүх хуралдааны явцад эрүү шүүлт тулгасан байна аа гэж шүүх бүрэлдэхүүн эсвэл шүүгч өөрөө үнэлснийг ойлгоод байна уу? Энэ тогтоогдвол гэдэг үг. Хэрвээ шүүгч өөрөө үнэлээд энэ эрүү шүүлт тулгасан юм байна аа. Тийм учраас би үнэлэхгүй ээ гээд шууд шийдэх гэж байгаа болбол энэ Үндсэн хуулийн бас нэг зарчимтай зөрчилдөх гээд байна. Шүүхийн шийдвэр гартал хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм

буруутайд тооцож үл болно гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл эрүү шүүлт тулгасан гэдэг тэр гэмт хэрэгт гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй байхад шүүгч урьдчилсан байдлаар гэм буруутайд тогтоогдсон шийдвэр гаргах гээд байна урьдчилсан байдлаар.

Тэгэхээр шүүгчид хэзээ ч урьдчилсан шийдвэр дүгнэлт байж болохгүй гэдэг бас нэг зарчим байдаг шүүгчид. Энэ өөрөө гэмт хэргийн тухай яриад байгаа шүү дээ. Нэг гэмт хэргийг ярьж байснаа эрүүдэн шүүсэн байж магадгүй өөр гэмт хэргийн тухай ярьж байгаа. Тэгэхээр 1 хулгайн хэрэг ярьж байснаа эрүүдэн шүүсэн гэмт хэргийг тогтоож шүүгч болох уу гэдэг ийм...

Д.Цогтбаатар: За Сайнзориг гишүүн микрофоныг нь өгье.

П.Сайнзориг: Энэ заалт Засгийн газрын өргөн барьсан төслийн 4 дүгээр зүйл дээр хөндөгдөж орж ирсэн юмаа. 16.12 дугаар зүйл маань. Зүйлийн нэг дэх хэсэг хөндөгдөж орж ирсэн. 4 дүгээр зүйл дээр байгаа. За энийг АН-ын бүлгээс бас өөрчлөн найруулах саналууд ирсэн. Бид бас хэлэлцээд одоо энийг нь бол ийм байдлаар оруулж ирж байгаа юм. Яах вэ зүгээр энэ дээр бас яг ажлын хэсэг бол нэгдсэн саналд хүрсэн зүйл бол байхгүй. Зүгээр яах вэ тодорхой хэмжээний. Би одоо ажлын хэсгээ ахалж байгаа мөртөө бас цөөнх болж байгаа тал байгаа. Би бол Засгийн газрын орж ирснээр нь үлдээчихье ээ. Засгийн газрын орж ирсэн маань ийм зүйлийг үлдээж байгаа юм.

Эрүү шүүлт тулгаж бусад хэлбэрээр хүнлэг бус хэрцгий харьцаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй ээ гэдэг л өгүүлбэрийг үлдээж байгаа юм. Энэ дотор нь байсан энэ зүйлийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар гэдгийг нь зүгээр хасаж байгаа юм байна лээ. Тэгэхээр яах вэ би энийг бол яах вэ зүгээр нэлээн ултай суурьтай гэсэн боловч бас өнөөдөр бас эрүү шүүлтийн гэмт хэргийг цаашдаа гаргахгүй байх. Энд хүний эрх зөрчигдөхгүй байх үүднээс энэ чиглэлээр одоо бас авагдсан нотлох баримтыг ер нь цаашдаа тухайн хэрэг дээр одоо мэдүүлэг тайлбар өгч байгаа хүнийг бас яллах байдлаар эх сурвалж болгож ашиглахгүй ээ л гэж байгаа юм.

Тэгэхээр Энхбаяр гишүүний хэлээд байгаа энэ зүйлүүд аль хэзээний хуульчлагдсан хүчин төгөлдөр хууль дээр байгаа байхгүй юу. Тогтоогдвол гэдэг энэ удаад бид нар хөндөөд байгаа зүйл байхгүй ээ Энхбаяр гишүүн ээ. Энэ өөрөө эргээд өмнө нь хүчин төгөлдөр буюу одоо шүүхийн эцсийн шийдвэр гарвал. Хоёр дахь хэсэг дээрээ бүүр яг таны хэлж байгаа санааг бүрэн хийчихсэн юмаа. 16.12 дээр энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан мэдүүлгийг эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хянан шийдвэрлэх нотлох баримтаар тооцож болно гээд. Одоо хүчин төгөлдөр хууль байхгүй юу. Энэ дээрээ зүгээр энэ 11.16.11 дүгээр зүйлд заасан журмаар гэдэг зүйл нь илүүдчихээд ийм байгааг бол зүгээр тодруулж бас Засгийн газраас өргөн барьсан юм байна лээ. Тэгээд энэ дээр бид хэд бол тооцохгүйгээс гадна зүгээр цаашдаа энэ хэрэгт одоо мэдүүлэг тайлбар өгөөд байгаа хүнийг яллах тэр эх сурвалж бүүр болохгүй шүү.

Ер нь ийм сэдлийг л одоо гаргахгүй байж болно. Дараа нь эрүү шүүлт гарсан тэрийг нь зөвтгөөд мэдүүлэг аваад, энийг нь үндэслээд бас хэн нэг этгээдийг яллаад байж болохгүй ээ л гэсэн. Тэгэхээр анхнаасаа одоо бас энэ хууль сахиулах байгууллагын хандлага энэ ерөөсөө хэргийн оролцогч гэдэг юм уу аливаа этгээдтэй эрүү шүүлт тулгаж болохгүй ээ л гэсэн энэ сэдлийг одоо оруулж одоо санааг зохицуулалтыг оруулж ирж байгаа. Тэгээд бид хэд бол энэ дээр нэмээд байгаа зүйл

байхгүй. Хуучин текст маань тогтоогдвол гэж байгаа. Энэ яг таны үндсэн хуулийн агуулгад зааснаар шүүхээс л мэдээж хүний гэм буруутай гэмт хэрэг үйлдсэн эсэх асуудлыг одоо шийднэ. Тийм учраас одоо энэ дээр одоо бас хүчин төгөлдөр хуулийн хүрээнд бас энэ агуулгууд практикууд бол тогтоод явж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Энэ Тэмүүжин гишүүний санал гэж би ойлгосон. За Энхбаяр гишүүн нэмж тодруулъя.

Б.Энхбаяр: Нэгдүгээрт бол энэ хууль санаачлагч Засгийн газрын хөндсөн зүйлийн үзэл баримтлалаас давуулж санал гарсан байна. Хоёрдугаарт энэ процессын хуулийн шинээр илэрсэн нөхцөл байдлын хүрээнд дараа нь авч үзэх үздэг энэ процесстой зөрчил үүсгэхээр байна. Ерөнхий ер нь хэнийг ч эрүүдэн шүүж болохгүй ийм эрүүдэн шүүсэн асуудал байх юм бол тухайн нотлох баримтаар тооцохгүй гэдэг энэ зарчим одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн процессын хуульд байгаа. Байгаа учраас Чимэгээ, Содномдаржаа 2 өнөөдөр сул явж байгаа. Эрүүдэн шүүгдсэн гэдэг нь шүүхийн шийдвэр гарсан учраас тэр нотлох баримтаар бусад асуудлыг үнэлээгүй учраас шүүхийн шийдвэр гарчихсан. Энэ өгүүлбэр бол өөрөө зөрчилтэй уншигдаад байна. Тухайн хэрэг учралыг хулгайн хэргийг...

Д.Цогтбаатар: Гүйцээгээд юу яачих Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Тухайн хулгайн хэргийг шийдэх явцад тэр мөрдөн байцаагч нь тэр нөхрийг зодож байгаад мэдүүлэг авчихсан юм байна аа гэдэг гэнэт мэдүүлэг гарч ирээд шүүх хурал дээр. Намайг бол зодож байгаад тулгачихсан юмаа гээд ярингуут шүүгч за ингээд эрүүдэн шүүсэн нь нотлогдсон байна аа гээд энийг авч тооцохгүй ээ гэдэг ийм шийдвэр шууд гаргах боломжтой юм уу, үгүй юу гэдэг хууль хэрэглээний зөрүүтэй байдлыг үүсгэх ийм заалт болчихоод байна. Энэ тохиолдолд яах вэ гэхээр бид нар урьдчилсан хэлэлцүүлэг гэж одоо яагаад хийсэн юм бэ гэхээр үнэхээр эрүүдэн шүүсэн байна уу, процессын алдаа гаргасан байна уу гэдгийг тусад нь авч үздэг урьдчилсан хэлэлцүүлгийн үе шатыг процессын хууль гаргасан ч ерөөсөө л энийг хянах гэж байна шүү дээ. Энэ үе шатаа шатан дээрээ яригдах юм уу, гэм буруугийн үе шатан дээрээ энэ нь тогтоогдвол гэдгээ ойлгох юм уу гэдэг...

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье. Ажлын хэсгийн гишүүн тайлбарлая.

Х.Тэмүүжин: Энхбаярын сүүлийн үг бол хамгийн чухал хэсэг нь байхгүй юу. Яагаад шүүхийг ийм олон херингтэй болгож байгаа юм. Яагаад шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг гэдэг нөхцөл байдал үүссэн юм гэхээр энэ хэн нэгний гэм буруугийн тухай яриагүй. Яг эрүү шүүлттэй холбоотой. Энэ нотлох баримтаар гэм буруугийн хурлыг хийх үү, үгүй юу гэдэг юм яригдаж байгаа юм. Энэ нотлох баримтаар гэм буруугийн хурлыг хийх гэсэн чинь гэм буруугийн хурлыг хийх гэж байгаа нотлох баримт чинь хууль зөрчиж явагдсан юм биш үү. Эрүү шүүлт одоо хэрэглэсэн юм биш үү гэдэг асуудал хөндөгдөөд тэр нь шүүх дээр тэр фактаа нотолж байгаа болохоос биш гэмт хэргийг нь нотлоогүй фактаа, нотлох баримтаа, тэгээд энэ бол нотлох баримтын чадваргүй буюу нотлох баримтад авагдахгүй юм байна аа гэдгээ шийдэж байгаа.

За олон улсын практикаар, зарчмаар эрүү шүүлттэй холбоотой одоо дэвшилттэй үзэл санаагаар бол юу вэ гэхээр зөвхөн эрүү шүүлт хэрэглээд авсан

нотлох баримт, баримт сэлт чинь хүчингүй болохоосоо гадна тэр эрүү шүүлтэд өртсөн эх сурвалж чинь энэ хэрэг дээрээ нөгөө ялагдлын эх сурвалж болохгүй шүү гэдэг зарчим дэлхий нийтээрээ явж байгаа. Тэгэхлээр энэ зарчим чинь одоо Монголд орж ирэх ёстой. Тэгэхгүй бол юу болдог вэ гэхээр за би түрүүн зодож байгаад мэдүүлэг авчихсан юм тэр хүчингүй болсон. Одоо өөрийг чинь зодохгүйгээр сайхан ярилцаж байгаад мэдүүлэг авчихъя хоёулаа гээд мэдүүлгээ аваад дахиад хэргийг шийдчихэж байгаа байхгүй юу. Энийг чинь бол нөгөө улс орнууд чинь энэ бол шударга биш тийм, шударга биш гэж байгаа юм. Тэгэхлээр энэ зарчим орж ирж байгаа энүүгээр.

Хамгийн их маргаан дагуулахаар асуулт нь юу байсан гэхээр нотлох эх сурвалж гэдэг ойлголт Монгол улсад одоо хууль зүйн ойлголт байгаа юм уу гэдэг асуудал яригдаад байсан. Тэгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дээр бол энэ үг угаасаа хэрэглэгдэж байгаа юм байна лээ. Тийм учраас яллах талын нотлох эх сурвалж болохгүй. Нөгөө эх сурвалжууд бол болж болно. Тухайн хэрэг дээрээ, мэдүүлэг одоо тайлбар өгсөн хэрэг дээрээ. Өөр хэрэг дээр бол яллах талын эх сурвалж болж болно шүү дээ. Энэ дээр одоо ингээд хулгайн хэрэг дээр эрүү шүүлтэд автаад гэрчийн мэдүүлэг өгчихсөн байсан, эсвэл юм гаргаад өгчихсөн байсан...

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя. Тэмүүжин гишүүний микрофоныг.

Х.Тэмүүжин: Яг энэ эрүү шүүлтэд өртөөд мэдүүлэг өгсөн хэрэг дээрээ эх сурвалж болохгүй яллах талын. Өөр одоо 2 жилийн дараа ч юм уу, авто аваарын хэргийг хараад гэрч болж болно шүү дээ. Тэрэн дээрээ бол эх сурвалж болж болно гэх мэтчилэн ийм тайлбартайгаар орж ирж байгаа. Энэ бол Монгол Улсын хувьд бол эрүү шүүлттэй холбоотой асуудлыг шийдэхэд их том алхам болно. Тийм учраас энэ өөрчлөлтийг бол бид бол зоригтой урагш нь хийгээд явах ёстой л гэж бодож байгаа юм.

Д.Цогтбаатар: Ярья ярья. Яагаад гэвэл энэ надаа ч хэлэх юм байгаа. Тийм Энхбаяр гишүүн яая. Ажлын хэсэг Сайнзориг.

П.Сайнзориг: Нэлээн ярьсан. Тэгээд бид буцаагаад өчигдөр, уржигдар хуралдсан ажлын хэсгээсээ нэг саналыг үлдээж өнөөдөр өглөө энийг эцэслэсэн санал байгаа. За мэдээж энэ дээр бол нэлээн дэвшилтэт үзэл санаа концептууд байгаа боловч бусад хэсгүүдтэй бас уялдаж хөндөгдөх болов уу гэдэг миний болгоомжлол бас байгаа. Тэгээд би мэдээж ажлын хэсгийн олонхын зарчмын дагуу энэ орж ирж байгаа. Би Тэмүүжин гишүүний яг үндсэн концепц санааг бол бүрэн дэмжиж байгаа. Тэгэхдээ энийг бид нар судалгаатай бөгөөд тодорхой зүйлүүдийг бас уялдуулж авч үздэг юмаа гэж байгаа юм. Тэгэхдээ ажлын хэсэг маань үндсэндээ бас олонхоороо дэмжиж байгаа учраас орж ирсэн. Би яах вэ зүгээр зарчмаа барьж байгаа.

Хоёрдугаарт яах вэ зүгээр Энхбаяр гишүүн үзэл баримтлалаас давж байна уу, үгүй юу гэдэг бол бас тусдаа асуудал байх. Яах вэ зүгээр хөндөгдсөн заалтын хувьд бол хөндөгдсөн ийм л зүйл байгаа гэдэг зүйлийг хэлье. Тэгээд яах вэ бид хэд бас хөндсөн заалтыг илүү тодруулж байна л гэж одоо бас эхэлж байгаа гэдэг ийм санааг хэлье. Тэгээд би бол ярилцахад энийг нээлттэй. Би хувилбараа бол бас хэлчихмээр байгаа юм. Энийг бас нэг талд нь гаргаад шууд унагаах, эсэргүүцэж байгаа зүйлдээ биш шүү. Энэ Тэмүүжин гишүүний ч санаа зовж байгаа зөв, ажлын

хэсэг би хэд гишүүд ч ойлгож байгаа. Энхбаяр гишүүний хэлээд байгаа бас зөв байгаа юм.

Тэгэхээр энэ Засгийн газарт эцсийн хэлэлцүүлэг дээр бас нэг Засгийн газарт чиглэл өгөх тогтоолыг бид нар оруулж ирэх гэж байгаа юм. Энэ дээрээ бид нар бас тодорхой чиглэлийг өгчихье. За Засгийн газрыг бас хүлээлгүйгээр Тэмүүжин гишүүний өөрийнх нь ажлын хэсэг байгаа юм. Эрүү шүүлтийн нөгөө сурталчлан сэргийлэх энэ чиглэлийн ажлын хэсэг дээрээ бид нар бас давхар яриад явъя аа гэсэн ийм зүгээр хувилбарууд байгаа. Энэ бол одоо юу гэдэг юм дэмжсэн дэмжээгүй гэдэг кнопоороо бүх энэ хаалгыг хаачхаж байгаа зүйл биш шүү. Энийг бол хэдүүлээ маш зөв бас ярилцаад явах ёстой гэдэг зүйлийг би бас зүгээр ажлын хэсэг ахалж бас энэ тал талын байр сууриудыг сонсож байгаагийн хувьд хэлж байгаа юмаа. Тэгээд шийдлүүд бол байгаа. Энэ зүйлээр өнөөдөр бүх зүйлийг шийдэх гээд байгаа, нэг талд нь гаргах гээд байгаа зүйл байхгүй ярилцах сэдэв мөн үү гэвэл мөн байгаа.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Би ямар зорилгоор оруулж байгаа санааг бол Тэмүүжин гишүүний саналыг бол ойлгочихлоо, одоо ойлгочихлоо. Яг энэ сайхан сэтгэл маань нэгдүгээрт Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийн үзэл баримтлалд бол байхгүй. Энэ бол концепцын өөрчлөлт орж ирж байна. Бүхэлдээ эрүүгийн процессын ажиллагаанд бүхэлд нь нөлөөлөхөөр өөрчлөлт орж ирж байна. Жишээлбэл одоо ингэж энийг яаж хуулийг бол сайхан санаад мөн муугаар бодож байж баталж байх ёстой. Энийг буруу хүн яаж буруу байдлаар ашиглаж болох эрсдэл байгаа вэ гэж бас бодож байх ёстой. Тийм учраас хуульч хүн бол сайхан санаатай ч байх ёстой, муу ч санаатай байх.

Муу санаагаар нь би бас бодож үзье. Энэ нэг бүтэлгүй амьтан энийг яаж ашиглаж болох вэ гэж. За энийг хэрэг учралыг хэрэг биш болох байдлаар ашиглах боломжтой тийм бас бичилт байна гэж би харж байна. Жишээлбэл шүүх хуралдааны явцад зодсон барьсан гэдэг яриа өгүүлэл гаргуулаад, тэр нь яг одоо ямарваа нэгэн байдлаар шүүхийн шинжилгээ, бусад гэрчүүд ийм юмаар нотлогдоогүй байхад за ер нь одоо ийм эрүүдэн шүүсэн нь тогтоогдсон байна аа гээд бусад нотлох баримтыг үнэлэхгүй гэж энэ заалтаар үнэлээд шууд хэргийг хаах. Энэ бол шүүгчийн бас нэг эрх нь байгаа юм. Тийм учраас тэр боломжийг бид нар бас харж байх ёстой.

Тийм учраас энэ сайхан сэтгэлийг тусдаа хуулийн төсөл барьж орж ирэхгүй болбол одоо бид нар бүрэн ойлгоцгүйгээр мөн хууль сахиулах Дээд шүүхийн жишээ саналгүйгээр шууд яриад байгаа байхгүй юу бид нар ийм процессын нарийн хуулийг. Прокурорын саналгүйгээр яриад байгаа байхгүй юу шууд бид нар. Тэгээд энэ бол жоохон аюултай байна аа л гэж би хэлэх гэж байна.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүнд микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Биднүүсийн нэгдэн орсон олон улсын гэрээ барина бичиг. Хүний эрхийн үндэсний комиссын удаа дараагийн миний тоолсноор одоо 7 дахь удаагийн илтгэл байна гэх мэтчилэн. Өнгөрсөн оны илтгэлд ч гэсэн бас дурдагдсан. Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хороо гэх мэтчилэн маш олон ажлын хэсгүүд байгуулагдсан. За эрүү шүүлттэй холбоотой. Энэ эрүү шүүлттэй холбоотой хэсгийн чинь хамгийн чухал хэсэг нь дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрчхөөд байгаа зүйл нь

эрүү шүүлтийн үр дүнд хэргийг шийдээд, тэрийгээ шударга гэж хэлж чадахгүй шүүл гэдэг зарчим шүү дээ. Ерөөсөө хамгийн богиноор.

Тийм учраас энэ бол нэг тийм концепц эвдээд байгаа юм байхгүй нэг. Хоёрт нь буруугаар ашиглах гэж эрүү шүүлтээс авсан мэдүүлэг болон баримтаасаа өөр баримт мэдээлэл, мэдүүлэг, гэрчээр асуудлаа нотол гэдэг. Цаад талд нь мөрдөн шалгах үйл ажиллагаа болон яллах үйл ажиллагаанд нээлттэй маш олон цонх байгаа шүү дээ. Хэргийг ганцхан юмаар хааж байна, ганцхан энэ нотлох баримтаар хааж байна гэдэг чинь хамгийн эргэлзээтэй хэрэг тэнд явж байна гэсэн үг байхгүй юу. Шүүх дээр биднүүс нэг зарчмыг одоо хүртэл мөрдүүлж чадахгүй байгаа. Хууль хэрэглэхэд эсвэл нотлох баримтыг үнэлэхэд эргэлзээ үүсвэл 2 салаа утга бий болбол шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ гэдэг энэ зарчмыг сүүлийн 30 жил огт хэрэгжүүлж чадахгүй байгаа шалтгаан чинь яг энэ байхгүй юу. Толгой дотроо юу гэж бодчихдог вэ гэхээр бурхан шиг бүгдийг харагч шиг яг энэ гэмт хэрэг хийсэн байж таараа, ийм болсон байж таараа гэж яллах талд нь түрүүлж алхаж гарчхаад, тэгээд түрүүгээрээ бүх ажлаа хийх гэж оролддог энэ Вишинскийн социалист аргаас одоо бид нар салах ёстой болчихсон.

Шүүх хөндлөнгийн л байх ёстой, шүүхийн хөндлөнгийн, бие даасан, төвийг сахисан тэр байр суурин дээр нь эхний урьдчилсан хэлэлцүүлэг явах ёстой. Тэгээд нотлох баримтаа гаргаж тавингуут хөндлөнгийн байгаа хэрэг болсон ч байж болдоггүй, болоогүй ч байсан магадгүй гэдэг энэ нөхцөл байдал дээрээ шүүх эрүү шүүлт...

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүн гүйцээгээд хариулъя.

Х.Тэмүүжин: Эрүү шүүлтийн үр дүнгээр орж ирж байгаа нотлох баримт, мэдүүлэг тайлбар байгаа юм байна шүү дээ гэх юм бол шүүх хамгийн түрүүнд энийг гэм буруугийн шүүх хуралдаан руу оруулахгүй байх үүрэгтэй шүүхийн. Хамгийн том зарчим чинь энэ шүү дээ. Тэгээд энэ зарчмыг нь энэ дээр хуульчилж өгч чадахгүй юм бол биднүүс одоо зүгээр л ил цагаанаар бид ямар ч нөхцөлд, Вишинскийн аргаараа, эрүү шүүлтийн туслалцаатайгаар цаашид одоо хэргийг шийдээд яваад байдаг энэ практикаа үргэлжлүүлнэ ээ гэдгээ Хууль зүйн байнгын хороо зарлаж байгаатай яг адилхан шүү дээ. Улсын Их Хурал зарлаж байгаатай яг адилхан. Тэгэхээр би энэ өнцгөөсөө асуудлаа анхаараасай гэж хэлж байгаа юм.

Д.Цогтбаатар: Би тэрэн дээр нэг өөрийнхөө саналыг хэлчихье. Энэ Тэмүүжин гишүүний ярьж байгаа жинхэнээсээ зөв шүү. Яагаад гэвэл олон улсын гэрээ конвенцуудад бид нар нэгдээд орчихсон байгаа. Бид нар дотоодын хуульдаа тусгаагүй байгаа ч гэсэн энэ чинь манай хууль болчихсон явж байгаа байхгүй юу. Бид даган мөрдөх ёстой. Тэгээд энэ дээр би зүгээр нэг ийм юм бодож байгаа. Сая Энхбаяр гишүүний бид нар яг муугаар нь бодох ёстой. Ер нь бол хуулийг гаргахдаа муу хүмүүст л зориулж гаргая. Сайн хүмүүст угаасаа хууль хэрэггүй ч байж болох байхгүй юу. Хуулийг муу хүмүүст л зориулж гаргана. Муугаар ашиглах гэж байгаа хүмүүст ашиглах боломжгүй болгож хийхийг л бид нар хууль гэж ярина шүү дээ. Тэгэхлээр муугаар бодох ёстой, муугаараа бодохлоор би энэ дээр нэг ийм юм бодож байгаа юм. Тэмүүжин гишүүний энэ ярьж байгаа эх сурвалж хамгийн гол ялгаа чинь Сайнзориг гишүүн энэ эх сурвалж гэдэг үг нэмээд ороод ирж байна шүү.

Тэгээд энэ дээр бол Тэмүүжин гишүүний саяын тайлбараас яг энэ нотлох асуудлаараа, нотлох баримтын асуудлаараа л эх сурвалж болохгүй. Түүнээс яг энэ хэргийнхээ хүрээнд өөр нотлох баримтыг зүгээр өөрөө өгчихсөн байж болно шүү

дээ. Тэр нь бол эх сурвалжаараа хэвээрээ үлдэнэ. Яг энэ нотлох баримтын хүрээндээ энэ хүн бол өөрөө эргээд эх сурвалж болохгүй ээ л гэж байна шүү дээ тийм ээ. Би бол тийм. Тэгэхлээр би энийг бол зөв гэж бодож байна. Яагаад би тэгж байна гэхлээр ер нь бол энэний чинь гол цаад санаа нь нээрээ сая Энхбаяр гишүүний ярьж байгаагаар нэг муу хүн эндээс мултарчхаж магадгүй гэж бид нар бодоод хийгээд байна шүү дээ. Гэтэл энийг үлдээчих ийм байдлаараа цаашаа үргэлжлэхлээр хэчнээн ч хүнийг зовоож мэдээлэл авч болзошгүй. Тэгэхлээр тэр олон хүнийг хамгаалах үүднээс энэ дээр энийгээ оруулах нь зөв болчхож байгаа байхгүй юу. Тэгэхлээр хууль хяналтын байгууллага дээр ирж байгаа ачаалал харин нэмэгдэж байгаа байхгүй юу. Та нар нотолмоор байгаа бол энийг хэрэглэхгүйгээр өөрөөр энийгээ нотлохгүй бол энэ чинь бол унана шүү. Энийгээ эхнээсээ мэдэж байна. Энэ хүн чинь эх сурвалж биш болчхож. Харин тийм.

Тэгэхлээр би ингэж байна. Энэ дээрээ тийм цоо шинэ асуудал ороод ирж байгаа юм байна. Би тэгэхлээр энэ дээрээ хэдүүлээ санал хураагаад явдгаараа явъя. Тэгээд Тэмүүжин гишүүний оруулж ирж байгаа энэ санал бол зөв шүү. Олон хүнийг тэр бид нар бол цаад санааг нь тэгэхлээр тал талдаа ойлголцож байна шүү дээ.

За ингээд Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 2.4 дэх заалтын бусад баримтыг гэсний дараа энэ хуульд заасан журмын дагуу гэж нэмэх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

42.6 хувиар энэ санал унаж байна. За цаашаа яах вэ үргэлжлүүлээд явах уу. Би горимын санал гаргаж байна. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. За манайхан бүгдээрээ анхааралтай яагаарай. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

57.1 хувиар санал дэмжигдлээ. Ингээд түрүүний санал хураалт хүчингүй боллоо. Одоо би ахиад уншиж танилцуулъя.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 2.4 дэх заалтын бусад баримтыг гэсний дараа энэ хуульд заасан журмын дагуу гэж нэмэх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.1 хувиар санал дэмжигдлээ. Ажлын хэсгээс гаргасан санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Жаргалангийн гаргасан саналыг уншиж танилцуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтын 5.1 дүгээр зүйлийн 5.4 дэх заалтын оролцох гэсний дараа таслал Шүүх шинжилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдийн өөрийнх нь зөвшөөрснөөр шинжилгээ хийлгэх гэж нэмэх.

Одоо 2 дугаар зүйл рүүгээ оръё. 2 дахь санал.

Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтын 1.8 дахь заалтын биечлэн эсхүл цахимаар гэснийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

63.3 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалтын 2 дахь хэсгийн эсвэл цахим хэлбэрээр гэснийг хасаж мөн заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

3.Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан оролцогч хэргийн материалтай ажлын 3-аас доошгүй өдрийн хугацаанд танилцах ба мөрдөгч хэргийн материалтай танилцах боломж нөхцөлөөр хангана. Хавтаст хэргийн материал танилцуулах үндсэн хугацаа 14 хүртэлх хоног байх бөгөөд хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан тус хугацааг мөрдөгч 14 хүртэлх хоногоор сунгаж болно гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Уг нь үг ажлын хэсгээс л байна шүү дээ. Дарга ажлын хэсгээс л байгаа. За санал хураалтаа явъя. Та тэгээд өөрийнхөөрөө саналаа өгье.

За ингээ тэгэх үү. Ажлын хэсгээс тайлбар өгсөн нь зөв. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Энэ саналыг бас гишүүддээ дэмжиж өгөхийг хүсэж байгаа юм аа. За уг санал маань одоо бол ерөөсөө хавтаст хэрэгтэй танилцах хугацаа ерөөсөө байхгүй байдаг. Өөрөөр хэлэх юм бол мөрдөгч үзэмжээрээ нэг цаг ч тогтоож болно, нэг өдөр ч тогтоож болно. Нэг ийм нөхцөл байдалтай явахаар яг нөгөө нэг тодорхой хэргийн оролцогч тэр дундаа хэргийн оролцогчийн эрх ашгийг хамгаалах гэж байгаа өмгөөлөгч нар яг энэ одоо хавтаст хэрэгтэйгээ бүрэн танилцаж мэтгэлцэх гэдэг юм уу, үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг энэ хуулийн хүрээнд одоо хамгаалах энэ асуудал дээр бас учир дутагдалтай байгаа юм аа. Тэгээд ерөнхийдөө хамгийн доод талын хугацаа 3-аас доошгүй хоног байна шүү. Ерөнхий хугацаа бол 14 хоног. За энэ одоо хэргийн ээдрээ төвөгтэй байвал дахиад нэг 14 хоногоор сунгах буюу 28 хоногийн л одоо хугацаа өгч байгаа нэг ийм заалт байгаа юм аа. Тэгээд энэ бол одоо бас энэ удаагийн одоо өмгөөлөх эрхийг хангах, ер нь өмгөөлөгч биш өөр өөрийгөө ч гэсэн одоо хамгаалах энэ юун дээр хэргийн бодит байдлыг шүүхийн мэтгэлцээний одоо үр дүнд бодитой тогтооход бол хамгийн чухал суурь заалт болов уу, үр нөлөөтэй байх болов уу л гэж үзэж байгаа.

Дээрээс нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг дээр бас асуудлаа хавтаст хэрэгтэй танилцаж байж бас хөндөж ярих бүрэн бололцоог нь бас одоо олгож байгаагаараа байгаад байгаа юм. Тэгэхээр бас энэ хугацааны зөрүүнүүд бол гарахгүй байх аа гэдэг зүйлийг бас хэлмээр байна аа.

Д.Цогтбаатар: Энэ уг нь ийм юм байхгүй дэгээрээ гэхдээ би Энхбаяр дарга үгээ хэлье. Данзанноров бас нэг энэ дээр тайлбар дараа нь хэлээрэй. Би өөрт чинь боломж олгоё. Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Сайнзориг гишүүн бол сая ингэж хэлж байгаа байхгүй юу. Хэргийн материалтай танилцах доод хугацаа 3 хоног байна аа гэж хэлж өгсөн гэж хэлж байна. Доод хоног өөрөөр хэлбэл 3-14 хоногийг яриад байгаа юм уу? Энийг уншихаар 3 хоногт багтаана гээд байгаа байхгүй юу. Нэг хоног байж болохгүй юм байна тийм үү. 2 хоног байж болохгүй юм байна. 3 ба түүнээс дээш юм уу? За тэгвэл ингэж нэг өгүүлбэрт багтааж болдоггүй юм байна энийг. 3 ба түүнээс дээш цаад хугацаа 14 хоног гэж хэлж болдоггүй юм уу. Тийм санаа яваад байгаа юм байна шүү дээ. Тийм ажлын 3-аас доошгүй өдрийн хугацаанд танилцана. Мөн үү. Үндсэн хугацаа нь 14 хоног байна. 14 үндсэн хугацаа нь 14 хоног байна. 3-14 хоног гэдэг л хугацаа яриад байгаа юм байна шүү дээ ерөөсөө тийм үү?

Тэгээд яагаад нэг өдөр танилцаж болдоггүй юм хурд хугацааг нь, яагаад 2 өдөр танилцаж болдоггүй юм, яагаад бид нар хялбаршуулсан шүүхийг гаргаж ирсэн юм. Тэгвэл хялбаршуулсан шүүхийн эрүүгийн процесс чинь байна шүү дээ бүүр даруй даруй гэдэг хугацаануудтай. Яагаад гэхээр маргаан байхгүй шүү дээ. Зөрчил байхгүй, гомдол байхгүй тийм хэргүүд дээр бид нар Хялбар хэргийн шүүх гээд сая нээлтээ хийсэн биз дээ. Хялбар хэргийн шүүхийн бид нар шийдэх хугацааг 3 хоногоор тавиад байгаа шүү дээ бүр. Хэрэгтэйгээ танилцах гэж 3 хоног гээд тавьчих юм бол хялбар шүүх чинь яах юм. Хэрэг чинь овоорох юм биш үү. Хялбар шүүх байгуулсны утга чинь яах юм. Энэ прокурор ямар саналтай байгаа юм, шүүх ямар саналтай байгаа юм, мөрдөгч нар ямар саналтай байгаа юм.

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон өгье.

Л.Данзанноров: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайд ээдрээ төвөгтэй олон хавтастай хэргүүд бас нэлээд байдаг. Ер нь бол одоогийн практикт мөрдөгч нар хэрэг танилцуулахдаа өмгөөлөгчдийг бол яг газар дээр нь тухайн цаг хугацаанд танилц гэдэг энэ одоо хандлагаар хандах байдал бол нэлээд түгээмэл байдаг. Тэгэхээр эрх тэгш мэтгэлцэх боломж олгох, харьцангуй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мөрдөн шалгах ажиллагаа дууссан хойно хэргийн материалтай танилцах эрх боломж нь нээгдэж байгаа учраас хэргийн материалтай бүрэн танилцсаны үндсэн дээр мэтгэлцээнд оролцох үүднээс хамгийн багадаа 3 хоног одоо үндсэн хугацаа бол 3-14 хоногт танилцаж, шаардлагатай бол 14 хоногоор сунгах ийм шаардлага байгаа гэж үзэж ажлын хэсэг дээр ярилцаж шийдвэрлэсэн. Энэ нь бол тухайн одоо этгээд хэрэгт холбогдсон этгээд болон өмгөөлөгчид хэргийн материалтай илүү их боломжит хугацаанд танилцаж хэрэгтээ энэ мэтгэлцээнд бэлтгэх энэ боломж нь илүү их нээлттэй болж байгаа гэсэн энэ үүднээс ярилцаж ингэж шийдвэрлэсэн байгаа.

Хялбар хэргүүдийн тухайд бол бас тусгай журмууд бас байж болно.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон Мөнхбаатар прокурор.

О.Мөнхбаатар: Тийм энэ дээр бас бид хэд ажлын хэсэг дээр ярилцсан. Тэгээд 3 хоног гэдэг бол доод хугацаа гэдэг бол бас байх уу, үгүй юү гэдэг дээр бас санал зөрүүтэй байгаа. Тэгэхээр одоо шүүхээр шийдвэрлэж байгаа нийт хэргийн 35-42 хувь нь бол хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан хэрэг байгаа. Тэгэхээр энэ нь тоон үзүүлэлтээ бодвол бас энэ 3 хоног гэдэг байх

шаардлагагүй юм уу гэдэг л саналтай байгаа. Хууль зүйн яамнаас анх боловсруулсан төсөл бол зүгээр 14 хүртэл хоногоор танилцъя, шаардлагатай бол дахиад 14-өөр сунгая гэдэг ийм л төсөл боловсруулагдсан. Тэгэхээр энэ төслөөрөө явахад бас болохгүй юм байхгүй ээ. Оролцогчдын эрхийг хангана гэдэг ийм саналтай байгаа.

Д.Цогтбаатар: За тэгэхлээр одоо хэдүүлээ тэгвэл энэ дээр үргэлжлүүлээд л саналаа хураагаад явах уу? Сайнзориг гишүүн микрофоноо нээе.

П.Сайнзориг: Энэ санал уначихвал бас нөгөө төсөл маань бас эргээд зөрчилтэй болох гээд байгаа. Аваачаад нөгөө 3 дугаар зүйлийн 11 дэх заалттай 2 дахь хэсгийн эсхүл цахим хэлбэрээр гэснийг хасаж гэдэг ийм юутай байхгүй юу? 2 үндсэндээ агуулгыг зэрэг хураах гэж байна гэсэн үг. Тэгэхээр энэ нь үлдчих юм бол бас хууль хоорондын зөрчил үүсэх гээд байгаа учраас дэмжээд явъя. Харин зүгээр Энхбаяр гишүүний одоо хэлж байгаа саналыг бид нар эцсийн хэлэлцүүлэг дээрээ буюу гүйцээн боловсруулах чиглэлээр авч байгаад нэг үзчихье.

Ер нь бол нийт хэргийн тэр нь одоо бас тодорхой 40 орчим хувь нь хялбаршуулсан журмаар явж байгаа боловч нөгөө талдаа үлдэж байгаа хэргүүд маань үндсэндээ хавтаст хэрэгтэйгээ бүрэн танилцаагүй учраас шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг рүү ороод буцаад шүүх дээрээ урьдчилсан хэлэлцүүлгээс буцдаг. Энэний цаана хүний эрх зөрчигдөх маш олон зүйлүүд байгаад байгаа юм аа. Яах вэ зүгээр прокуроруудтайгаа бид нар ярьсан. Энийг зүгээр ингээд практикаараа зөв тогтооно гэхээр бас их үзэмжээрээ болох гээд байгаа юм. За нэг хавтаст хэрэгтэй хэрэг дээр нэг ч гэдэг юм уу яг ингээд бас их хэцүү. Хавтаст хэргийн тоондоо биш юм байна лээ. Магадгүй нэгхэн одоо юу гэдэг юм хуудас цаас байж болох боловч хэргийн оролцогч олон байж болно. Бүгд танилцах боломжтой байх ёстой.

Тэгэхээр энэ нөхцөл байдлаас бодохгүй бол хэдүүлээ нэгхэн нүүр хуудсан юмыг нэг 3 хоногт танилцаж чадахгүй байхдаа яадаг юм гэж бас бас хэлж боломгүй. Яг амьдрал баян магадгүй бүгд хялбаршуулсан гэдгээ хүлээн зөвшөөрч байгаа боловч оролцогчид одоо бас олон байж болно. Одоо өнөөдрийн нөхцөл байдлыг харахад бол ерөөсөө хэдэн ч хүн оролцох бололцоотой ийм гэмт хэргүүд гарах магадлалууд энэ цахим технологийг ашиглаад гарч байна шүү дээ.

Тэгэхээр ийм зүйлүүд байгаа юм аа. Тэгээд энэ өөрөө нөгөө хавтаст хэрэгтэйгээ бүрэн танилцаагүй учраас дараа нь би ерөөсөө мэдээгүй байж байхад надад нэг ийм юм яасан, ерөөсөө мэтгэлцэх бололцоо олгосонгүй ч гэдэг юм уу ийм зүйлүүд байгаад байгаа юм аа. Энийг хэдүүлээ зүгээр би одоо бас гишүүдээсээ дэмжээд гаргачих. Би Энхбаяр гишүүний саналыг ажлын хэсэг дээрээ хүлээж аваад бид хэд бас гүйцээн боловсруулах чиглэлийг Улсын Их Хурлын чуулган дээрээс болоод эсвэл одоо 3-ны 2-аар дараагийн найруулгын саналыг сайжруулах байдлаар оруулж ирье ээ гэдэг ийм саналыг хэлчихмээр байгаа юм. Одоо шууд энэ дээр найруулна гэхээр бас дэгээ...

Д.Цогтбаатар: Тийм тийм. Тэгвэл ингэе одоо санал хураалтаа явуулъя. Тэгээд ямар ч байсан манай энэ юуныхан Байнгын хорооныхон тэмдэглээд аваарай. Сая 2, 3 саналыг нь гүйцээн боловсруулахаар болж байна. Энийг бас гүйцээн боловсруулахаар ер нь даргаас чиглэл авъя гэсэн ийм юугаар явъя. За тэгээд санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ. За энэ дээр ингээд гүйцээн боловсруулах чиглэл авна шүү манайхан.

16.Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 14 дэх заалтын заалтын 8 дахь хэсгийн хавсаргуулна гэснийг хавсаргаж болно гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 3 дугаар зүйлийн 15 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 15 дахь заалтын 9 дэх хэсгийн оролцогч гэсний дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэж нэмэх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс нэг зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байгаа.

19 дүгээр санал. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 4 дүгээр зүйлийн 34.10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн төлөөлж болно гэснийг төлөөлнө гэж гэснийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

За тэлье юу яая. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Энэ дээр би нөгөө олон нийт тэр дундаа өмгөөлөгч нартаа хандаж хэлж байгаа. Хууль зүйн байнгын хорооны даргын нэр дээр бас нэлээн олон саналууд ирсэн. Энэ бас нөгөө хэдийгээр одоо санаа нь бас зөв боловч бас практик дээр шууд буруу тогтох магадлал байгаад байгаа. Ер нь зүгээр бас энэ өмгөөлүүлэх эрхийг шууд ингэж хязгаарлуулахад бас учир дутагдал байна аа гэж үзэж байгаа. Шүүгдэгч хэд хэдэн өмгөөлөгч авч байгаа бол шүүх хуралдаан тодорхой асуудлаар мэтгэлцээд нэг өмгөөлөгч бусдыгаа төлөөлнө гээд нөгөө эрх ашгаа хамгаалуулах хүнийг төлөөлж байж байгаа этгээдүүд маань дотроо дахиад бас бие биеэ төлөөлөх асуудал ингэж орж ирж байгаа. Өмгөөлөгч нар маань нэлээн эмзэг хандсан. Тэгээд

энэ асуудлыг одоо энэ Засгийн газрын өргөн барьсан төслөөс хасаж байгаа гэдгийг би бас протоколын хувьд олон нийтдээ бас мэдээлэл өгөх үүднээс өгч байгаа. Нэлээн олон өмгөөлөгч нар энэ дээр эмзэг хандсан.

Бид одоо бас үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалах бололцоогүй болгож байгаа юм байна. Яг энэ давтагдсан агуулгаар яриулахгүй байх асуудлыг угаасаа шүүх хуралдааны явцад хуралдаан даргалагч буюу шүүгч өөрөө зохицуулаад явдаг асуудал дээр ийм зүйлээр одоо бас дараа нь нугалаа үүсэх ийм заалт оруулах нь буруу гэдэг зүйлийг бас олон өмгөөлөгч нар ярьсан учраас бас энэ асуудлыг энэ удаадаа зайлшгүй бас томъёоллын хувьд ч гэсэн их эргэлзээтэй орж ирсэн учраас хасаж байгаа гэдэг зүйлийг би бас энэ одоо зүйлийн хувьд протоколын хувьд бас хэлээд өмгөөлөгч нарын санал бас бүрэн тусаж байгаа гэдэг зүйлийг хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Би сая энийг уншихдаа харин нэг тоо буруу уншчихаж. Тийм учраас би дахиж уншиж танилцуулъя.

19 дүгээр санал. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 4 дүгээр зүйлийн 34.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн төлөөлж болно гэснийг төлөөлнө гэж гэснийг хасах гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн гишүүн мөн л дөө. Тэгэхдээ энэ нөгөө 34.16 дугаар заалт дээр 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг дээр 2 ба түүнээс дээш удаа давтагдаж гэснийг хассугай гээд нэг ийм заалт орж ирчихээд тэгээд манай ажлын хэсэг хөндөөгүй ингээд цаашаа явчихсан нэг ийм заалт үлдчихээд байгаа юм. Тэгээд энэ дээр бас бид хэд яаж санал хураах юм бол доо гээд учир нь гэвэл энэ 34.16 чинь яг энэ заалтыг хасчихлаар шүүх хуралдааныг хойшлуулахгүйгээр одоо ингэж байгаа юм. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасныг үндэслээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулах нөхцөл болж байвал шүүх хуралдааныг хойшлуулахгүй байж болно гэж байгаа юм. Тэгэхээр 1 удаагийн тохиолдол дээр л шууд шүүх хурлыг бол тухайн шүүгч болбол энийг санаатай гэж үзэх юм бол хурлыг бол шууд явуулах болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө 2 ба түүнээс дээш удаа давтагдвал гээд ингээд тоог нь заачихсан байсан чинь одоо ерөөсөө тоо заагаагүй.

Дээрээс нь энэ яг нөгөө санаатай саад учруулах гэдгийг бол тухайн шүүх хуралдааныг удирдаж байгаа шүүгч өөрөө субъектив байдлаар яг тухайн мөчид шийднэ шүү дээ. Тэгэхээр шууд шүүх хуралдаан үргэлжлээд ингээд өмгөөлөгчгүй хуралдаан үргэлжлэх ийм нөхцөл рүү оруулах гээд байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ нөгөө тоог хасаж байгааг би бол дэмжихгүй байгаа юм. Тэгээд нөгөө ажлын хэсэг дээр ерөөсөө хөндөгдөөгүй болохоор тэгээд яг яах юм бүү мэд. Харин тийм тэгээд

нөгөө ажлын дэд хэсэг хөндөөгүй учраас энийг ажлын хэсэг хөндөхгүй гээд ингээд хаачихсан байхгүй юу. Тэгэхдээ энийг ямар ч байсан протокол дээр би ямар ч байсан тэмдэглүүлээд л үлдээчихье тэгэх үү. Ажлын дэд хэсэг хөндөөгүй.

Д.Цогтбаатар: Яах вэ протоколд тэгээд сая юу нь үлдэг ээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс нэг зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байна аа.

20 дугаар санал. Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 5 дугаар зүйлийн 16.2 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн энэ хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан журмаар гэснийг гэснийг хасаж 16.12 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3 дугаар зүйлийн 10 дахь заалт болгох.

10 дугаар санал. 16.12 дугаар зүйлийн нэг дэх хэсэг. Нэг эрүү шүүлт тулгаж бусад хэлбэрээр хүнлэг бус хэрцгий харьцаж тайлбар мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан тайлбар мэдүүлэг бусад нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй бөгөөд тайлбар мэдүүлэг өгсөн хэрэгт нь тухайн хүнийг яллах талын нотлох эх сурвалж болгохгүй гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тэгье тэгвэл Тэмүүжин гишүүн чуулган дээр цөөнх болох нь байна тиймээ.

За 50, 50 хувь санал дэмжигдсэнгүй.

Төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс нэг зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байгаа.

21 дүгээр санал. Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 6 дугаар зүйлийг хасах гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

74.4 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төсөлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн найруулгын саналаар санал хураалт явуулъя.

Найруулгын 4 санал байгаа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн төслийн 1 дүгээр зүйл болон 3 дугаар зүйлийн зүйл гэснийг тус тус хасаж 1 дүгээр зүйлийн 21 дэх заалтын 8 дахь хэсгийн заасныг гэснийг заасан журмын гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн шинжээч гэсний дараа сэжигтэн гэж гэснийг 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын. Уучлаарай.

Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 2.12 гэснийг 2.13 гэж мөн зүйлийн 7 дахь заалтын 5 гэснийг 6 гэж, мөн зүйлийн 13 дахь заалтын 6 дахь хэсгийн хоногийн гэснийг өдрийн гэж тус тус өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 2.12, 2.13, 2.14, 2.15, 2.16, 2.17 гэснийг 2.11, 2.12, 2.13, 2.14, 2.15, 2.16 гэж. Мөн зүйлийн 31.2 дугаар зүйлийн гарчгийг гэснийг 31.2 дугаар зүйлийн гарчгийн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа хийгдэх ажиллагаа гэснийг гэж мөн зүйлийн 31.3 дугаар зүйлийн гарчгийг гэснийг 31.3 дугаар зүйлийн гарчгийн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах гэснийг гэж тус тус өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гаргасан санал байхгүй байгаа. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. За байхгүй байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 2 дугаар зүйлийн 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс гэснийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78.6 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг танилцуулна аа.

Дараагийн асуудалдаа оръё.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг явуулъя.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна аа. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Сайнаа, Энхбаяр аа. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нэр бүхий 20 гишүүн өргөн барьсан. Хөндөж байгаа асуудал ерөөсөө тавхан асуудал байгаа.

Нэгдүгээрт Эрүүгийн хууль дээр байгаа худал мэдээлэл тараах гэсэн гэмт хэрэг бий. Энэ гэмт хэргийг дотор юу бичигдсэн бэ гэхээр хуулийн этгээдийн алдар хүнд гэдэг ойлголт бичигдсэн. Энэ зүйл заалтад дурдагдаж байгаа хуулийн этгээд гэдэг нь одоо ойлголтын ард сүүлийн үед харагдаж байгаа нэг үзэгдэл нь юу вэ гэхээр төрийн байгууллагууд гомдол санал гаргадаг болж хувирсан. Тэр дундаа хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас илүү гомдол санал гаргах тохиолдолд илүү дийлэнх нь болж эхэлж байгаа. Тийм учраас эрүүгийн хуулийн энэ зүйл заалтад байгаа хуулийн этгээд гэдэг одоо нэр томьёоны ард төрийн байгууллага багтахгүй ээ гэдэг тайлбарыг бичиж өгч байгаа.

Гол зарчим нь яагаад ингэж бичиж өгч байгаа вэ гэхээр орчин үеийн үндсэн хуулийн байгуулал үндсэн хуулийн дэг журмаар юу гэж илэрхийлж байгаа вэ гэхээр дигнити буюу нэр төр, алдар хүнд гэдэг ойлголтыг зөвхөн иргэнтэй холбогдуулж тайлбарлаж байгаа. Төртэй холбогдуулж бол ямар нэгэн ажил хэргийн алдар хүнд гэдэг ойлголтыг бол хэрэглэхгүй байгаа. Гэтэл Монгол Улсад Эрүүгийн хуулийн энэ зүйл заалт ойлгомжгүй байгаа тайлбар шаардаж байгаа байдал нь төрийн байгууллагууд иргэдээсээ илүү алдар хүндтэй байх, иргэнийхээ эсрэг одоо ажил хэргийн нэр хүндэд халдлаа гэдэг байдлаар гомдол санал гаргах үйл явц бол энэ гараад байгаа учраас ардчилсан улсад үндсэн хуулийн байгууллага бүхий ийм улсад ийм зарчим Эрүүгийн хуулиар байж болохгүй ээ. Төр ганцхан тохиолдолд одоо хуулийн этгээд гэдэг статусыг эдэлж байгаа. Энэ нь иргэний эрх зүйт. Эрүүгийн буюу нийтийн эрх зүйд бол ийм байдлаар одоо төр хуулийн этгээд гэдэг нэрийн дор нуугдах нь өөрөө засаглаж байгаа субъектүүд бол байж боломгүй зүйл учраас тайлбар ийм байдлаар хийж байгаа.

Хоёрт нь Эрүүгийн хууль дээр нийгэмд аюултай, нийгэмд учруулсан хор уршиг гэх мэт онц аюултай хор уршиг гэх мэтчилэн ойлголтууд эрүүгийн хуульд хуульчлагдсан байгаа. Эрүүгийн хуульд хэмжигдэх боломжгүй субъектив үнэлэгддэг ийм нэр томьёо орсноороо иргэнийг, хүнийг шийтгэж байгаа хуулийг одоо нөхцөл байдлынх нь хувьд иргэний эрхийг дордуулж байгаа. Социализмын маягтай ийм ойлголтыг Эрүүгийн хуулиас хасахаас өөр аргагүй. Хууль тогтоомжид нийгэм гэдэг энэ ойлголт хуульчлагдаж болдог. Гэхдээ менежмент хийх удирдлага зохион байгуулалт хийх тийм үйл явц дээр ашиглагдахаас биш хэн нэгнийг яллах, шийтгэх хууль дээр бол энэ ойлголт бол хуульчлагдаж болохгүй. Хавсарсан судалгаан дотор шүүхийн шийдвэр дотор хамгийн их эш татагдаж, ашиглагдаж байгаа нэр, томьёо бол энэ байна лээ.

Орчин үед нийгэмд аюул учруулахгүй мөртөө хүнд аюултай үйлдүүлдэг гэмт хэрэг гэж хуульчилдаг болчихсон. Олон нийтэд аюултай үйлдлийг тусгай ангид шууд зааж байгаа. За Үндсэн хуулийн дэг журмыг эвдэж байгаа бол Үндсэн хуулийн дэг журам гэдгээр нь бичиж байгаа. Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг байгаа бол хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэдгээр нь бичиж байгаа. Нийгэмд аюултай гэдэг энэ нөгөө гэмт хэргийн шинж чанараасаа болоод эрүүгийн хуульд бичигдчихээр хэмжигдэхгүй субъектив ойлголт байгаа учраас энийг хасъя гэдэг байдлаар оруулж ирж байгаа.

Гуравт нь, нэр томьёог жигдлэх зорилгоор дахиад шалган шийдвэрлэх гэдэг эрүүгийн хуульд бичигдсэн ойлголтыг хянан шийдвэрлэх гэж бичиж байгаа. Эрүүгийн хуульд яагаад шалган шийдвэрлэх гэдэг бичигдсэн гэж бичигдсэн нь ерөөсөө жоохон ойлгомжгүй байгаа. Монгол улсад хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой 3 одоо үндсэн тогтолцоо байгаа. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа байна, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа байна, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа байна. Нотлох баримт хуурамчаар үйлдэгдвэл энэ 3 хянан шийдвэрлэх ажиллагаанд гурвууланд нь хамаатай байгаа. Гэтэл эрүүгийн хууль дээр шалган шийдвэрлэх гээд хянан шийдвэрлэх ажиллагаанаас тусдаа юм шиг өөр ойлголт хуульчлагдсанаас болоод хууль хэрэглээний хувьд нэг мөр хэрэглэхэд жоохон төвөг учирч байгаа. Тийм учраас нэр томьёог жигдлэх зорилгоор шалган шийдвэрлэх гэдэг ойлголтуудыг бүгдийг нь хянан шийдвэрлэх болгож өөрчилж байгаа.

Дөрөвт нь, эрүүгийн хариуцлага гэдэг ойлголт байгаа. Эрүүгийн хууль дээр эрүүгийн хариуцлага бол ял албадлагын арга хэмжээ гээд биччихсэн. Тэгэхдээ хамгийн одоо аюултай их хэрэглээ нь бол Эрүүгийн хуулиас гадна хэрэглэгдэж байгаа. Эрүүгийн хуулиас гадна маш олон хууль дээр эрүүгийн хариуцлага хүлээсэн бол гээд биччихсэн байгаа. Эрүүгийн хариуцлага хүлээсэн бол тэгнэ гээд эрх зүйн байдлыг дордуулах бол байдлаар биччихсэн. Эрүүгийн хариуцлага гэдэг дотор нөгөө албадлагын арга хэмжээ нь орчхож байгаа учраас ял аваагүй мөртөө албадлагын арга хэмжээ хэрэглэгдсэн хүн эрүүгийн хариуцлага хүлээсэн болж хувирч байгаа юм. Ийм ойлгомжгүй, тодорхойгүй нөхцөл байдал үүссэн учраас эрүүгийн хариуцлага гэдэг ойлголтыг ял албадлагын арга хэмжээгээр нь бичээд, хэрвээ өөр хууль дээр хэрэглэхдээ ял хүлээсэн бол гэж эрүүгийн нөгөө иргэний эрх зүйн байдлын нөхцөлийг дордуулж болно, хязгаарлаж болно. Эрүүгийн хариуцлага гэдэг ерөнхий, хэт ерөнхий ойлгомжгүй дотроо одоо олон зүйл агуулсан энэ нэр томьёог ашиглахыг бол хязгаарлаж байгаа.

Яг үнэндээ эрүүгийн албадлагын арга хэмжээ Зөрчлийн хууль дээр байгаа албадлагын арга хэмжээ 2 ялгаагүй байгаа. Тийм учраас хууль сахиулах юм уу, гэмт

хэрэгтэй тэмцэж байгаа байгууллагын албан тушаалтан Зөрчлийн хуулийн албадлагын арга хэмжээг ч эрүүгийн одоо албадлагын арга хэмжээ гэж ойлгож эрүүгийн хариуцлага болгож хэрэглэх боломж эрх мэдлийнхээ хувьд нээлттэй байгаа. Тэгээд энэ бол үнэхээр одоо юу гэдэг юм хууль хэрэглээний хувьд бол зах хязгаараа тэлэх бололцоотой ийм хэрэглээ байгаа.

Тав дахь нь бол мөрдөн шалгах үйл ажиллагааны нууцтай холбоотой зүйл заалт дээр өөрчлөлт оруулж байгаа. Одоо Эрүүгийн хуульд байгаа Мөрдөн шалгах ажиллагааны нууцын 1 дүгээр зүйлээрээ албаны буюу мөрдөн шалгах ажиллагаанд хэрэгжүүлж байгаа байгууллага, албан хаагч, албан тушаалтнууд өөрсдөө нууцаа хадгалах үүрэгтэй байгаа байх ёстой тэр нууцыг одоо Монгол Улсын 3 сая 600 мянган иргэн бүгдээрээ үүрэхээр бичихсэн байгаа. Яг нөгөө мөрдөн шалгах ажиллагааны ажиллагаанд хэрэглэгддэг нууц мөрдөн шалгах ажиллагаа гэх мэтчилэн тэр зүйлүүд нь болохоор тодорхойгүй хуульчлагдсан байгаа. Тийм учраас субъектийг нь тодорхой болгох, нууцлагдах объектыг тодорхой болгох, энэ ял халдаан хэрэглэх бололцоотой байгаа зүйл заалтуудыг сайжруулах одоо хязгаарлаж, зохицуулалтыг сайжруулах зорилготойгоор энэ мөрдөн шалгах ажиллагааны нууц гэдэг энэ зүйл гэмт хэргийг бүхэлд нь шинэчилж өөрчилж байгаа ийм 5 зүйл л байгаа.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүнд баярлалаа. Хуулийн төсөл үзэл баримтлалтай төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Энхбаяр гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Яах вэ зүгээр энэ хуулийн төсөл дээр мэдээж бас тодорхой дэмжих саналууд байна аа байна. Энийг бол үгүйсгэхгүй. Тэгэхдээ бас яг хууль санаачлагчийн тайлбар юунаас харахаар бас нэг жоохон тийм ойлголтын зөрүүнүүд бол байна аа. Социализмын үеийн ойлголт одоо орчин цагийн эрх зүйн ойлголт энэ тэр гэсэн зүйлийг зүгээр нийгмийн аюул гэдэг зүйл дээр ярьж байна. Энэ нийгмийн аюул гэдэг зүйлийг социализмын ойлголт бол биш л дээ, одоо ч нийгэм байж байгаа. Нийгэмд ямар хортой үйлдлүүдийг бид таслан зогсоож, энийгээ эрх зүйн ямар албадлагаар эсвэл ямар хариуцлагаар тооцох вэ гэдэг бол хууль тогтоох байгууллагын бүрэн эрхийн асуудал байхгүй юу. Энэ өөрөө байж байж хууль тогтоогч үзэмжээрээ дурын үйлдлийг гэмт хэргийн тусгай ангид Эрүүгийн хуулийн тусгай ангид буюу гэмт хэрэг болгож бичихгүй байгаа юм. Магадгүй бусад оронд зүгээр би жишээ авъя ингэе. Бусад орны жишээг харахаар улаан гэрлээр гарлаа, эсвэл эмэгтэйчүүд, нөгөө нүүр халхалсан юмыг зүүж байгаа гэмт хэрэг гээд тооцож байгаа орнууд ч байгаа. Тэр нийгэмд аюултай аюулгүйгээр нь ялгах юм бол бас өөр үзэгдэл байхгүй юу. Тэгэхээр бид нар эрх барьж байгаа буюу хууль тогтоогч гэдэг юм уу хэн нэгний үзэмжээрээ тэр үйлдлийг сайшаахгүй байгаа үйлдлийг бас хэмжүүрээр авч үзэж байгаа нь энэ үйлдлийг чинь гэмт хэрэгт тооцож байгаа асуудал чинь нийгэмд аюултай юм уу гэдгийг чинь үзэж энэ ойлголтыг барьж байгаа юм аа.

Өөрөөр хэлэх юм бол хэдийгээр энэ эрх зүйн эсрэг үйлдэл байх боловч нийгэмд аюулгүй аюултай үйлдэл байж байж гэмт хэрэгт тооцно шүү гэдэг үндсэн санааг шүүхэд биш хууль тогтоогчид баримжаа авахын тулд хийсэн ойлголт байхгүй юу. Гэтэл энэ үзэл баримтлал танилцуулгууд дээр шүүх энийг буруу хэрэглээд байна аа гэж байгаа юм. Шүүх яаж хэрэглэж байгаа вэ гэдгийг яг баримтаар та хэлээч. Энэ шүүхтэй холбоотой юм биш. Шүүх хэзээ ч энэ 2.1-ийг барьж хэрэг шийдэхгүй. Энэ шүүх бол Эрүүгийн хуулийн тусгай ангийн яг тодорхой гэмт хэргийн

шинжийг барьж шийднэ. Тэгэхээр энэ дээр ингээд одоо ийм ойлголтын асуудлуудаасаа гараад энэ харин дурын үйлдлээ бид нар гэмт хэрэгт тооцох юмыг нээж байна, нээж байна. Тэгээд энэ ойлголт дээр дахиад Эрүүгийн хуулиар ойлгомжгүй нэг нэр томъёо орж ирээд байгаа юм. Энийг бас Тэмүүжин гишүүн тайлбарлаж өгөөч ээ гэж байгаа юм. Юу вэ гэхээр хор аюул гэдэг. Хор аюул гэж юу гэсэн үг вэ? Хор уршиг одоо энэ дээр хохирол хор уршиг гэдэг ойлголтоос гадна энэ томъёолол дотор хор аюул гэдэг ойлголтыг дахиад оруулаад ирж байгаа юм. Дахиад үзэмжээрээ тайлбарлана. Бүүр дордуулчхаж байгаа байхгүй юу. Хор аюул нь хэнд байх юм бол гэмт хэрэгт тооцохгүй гээд байгаа юм.

Бид хэд чинь тодорхой юм ярьж байсан шүү дээ. Нийгэмд аюултай байвал тэрийг аюулгүй байх юм бол тэгэхдээ эсрэг, эрх зүйн эсрэг үйлдэл байсан ч гэсэн арай гэмт хэрэгт тооцож болохгүй шүү гээд хааж өгч байсан зүйлийг тэрийг нь авч хаянгуутаа тэр бол социализмын үеийн ойлголт юмаа гэнгүүтээ хор аюул гээд хэний хэнд хор аюул учруулах гээд байгаа нь мэдэгдэхгүйгээр ийм үзэмжийн асуудлыг орж ирж байгаа буруу.

Хоёрдугаарт энэ албадлагын арга хэмжээг эрүүгийн хариуцлагын бүрэлдэхүүн хэсгээс гаргачих юм бол.

Д.Цогтбаатар: Нэг минут нэмж өгье. Сайнзориг гишүүний микрофон.

П.Сайнзориг: Ялаа эдэлж дуусаад жишээ нь хөрөнгө хураах албадлагын арга хэмжээ, сургалтад суух албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхгүй ээ гээд явж байна шүү дээ. Би шүүхийн шийдвэр дуусчихсан. Тэгэхээр энэ ингээд уг нь хосолмол байдлаараа явж бас заримдаа ингэж үр нөлөөтэй хэрэгждэг. Яг энийг салгаснаараа хэний эрх зүйн байдлыг дордуулаад байгаа уг нь зүйл байхгүй л ээ гэж би зүгээр харж байгаа. Тэгэхдээ Тэмүүжин гишүүний бас яг гол зорилго энэ тээшний бас сонсохыг хүсэж байна. Тэгэхээр би бол нөгөө аливаа зүйл дээр тэр социализм ч байдаг юм уу, энэ юундаа биш шүү. Энэ бол тодорхой хэмжигдэхүүндээ байсан. Одоо таны энүүгээр харин хор аюул гэдгийг хууль тогтоогч нар сууж байгаад ер нь бид нарт хор аюул юм биш үү. Эсвэл энэ хэнд хор аюул учруулах гээд байгааг нь тоохгүйгээр бид хэд тодорхой үйлдлүүдийг зүгээр дураараа гэмт хэрэгт тооцох үүд хаалгыг харин таны энэ хуулийн төслөөр нээчих вий дээ гэдэг болгоомжлол надад байгаад байна. Тэгэхээр энийг одоо бас яг албан ёсоор.

Тэгээд хамгийн сүүлд нь Засгийн газар маш олон саналуудыг өгсөн байна. Хэр зэрэг тусгасан юм бэ, хэдэн хувьтай тусгасан юм бэ.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Сүүлийнхээс нь хариулъя. Прокурор болон Засгийн гараас ирсэн санал дотор жишээ нь нөгөө худал мэдээлэл тараахтай холбоотой хэсэг дээр төр хуулийн этгээдийн энэ зүйлд заасан хуулийн этгээдийн гэдэгт төр хамаарахгүй ээ гэсэн хэсэг дээр Иргэний хууль татаад Иргэний хууль дээр төр хуулийн этгээд байдаг шүү дээ гэсэн тайлбар хэлсэн байна лээ.

Би нэг түүх ярья. 2002 онд одоогоос 23 жилийн өмнө иргэний хуулийн шинэтгэлийн шинэчлэл болох гээд хуулийн төслүүд Улсын Их Хурлаар орж ирээд тухайн үед Хууль зүйн дэд сайд нь Мөнх-Оргил байсан юм. Тэгээд иргэний хуульд хэрэглэсэн иргэн гэдэг үгийг хууль зүйн ойлголтыг бодгаль гэдэг үгээр солих гээд тэгээд тэр үед Улсын Их Хурлын гишүүн байсан Дулам гуай бодгаль гэдэг чинь одоо

төвд шашны маягийн ойлголт эгэл хүн гэсэн утгатай үг шүү дээ. Тэгээд та нар хууль уншихаараа эгэл хүн хэлцэл хийгээд, эгэл хүн гээд ингэж унших юм уу гээд тэгсэн чинь тэр үеийн хуульч Улсын Их Хурлын гишүүдийн нэг Шаравдорж гуай биднүүс иргэний үнэмлэхээ тэгээд бодгалийн үнэмлэх гэж одоо солих уу гэж. Тэгээд чуулган тэр үед нэлээн инээд хөөртэй болоод, бодгаль гэдэг үг унаж байсан юм.

Дараа нь ямар яриа гарсан бэ гэхээр одоо Чимэд багшийн хэлсэн үг Монгол Улсын нэлээн нэртэй хуульч Монгол Улсад байдаг хувийн болон нийтийн эрх зүйн ялгааг ойлгодоггүй юм байна. Хувийн эрх зүй дээр хэрэглэж байгаа одоо иргэн гэдэг ойлголт, нийтийн эрх зүй дээр хэрэглэж байгаа иргэн гэдэг ойлголт давхцаад байгаа учраас хууль зүйн үр дагавар нь өөр учраас тэнд одоо иргэн гэж үг хэрэглэж хувийн эрх зүй дээр болохгүй байгаа учраас солих гэж байгаа юм. Нийтийн эрх зүйд хэрэглэж байгаа иргэний үнэмлэх гэдэг ойлголт бол хэзээ ч өөрчлөгдөхгүй иргэнийхээрээ л байна. Хувийн эрх зүйд хэрэглэж байгаа хэлцэл хийх гэж байгаа нь аль нэг улсын иргэн байх заавал албагүй, зүгээр л хүн байхгүй юу. Хүн хувиараа өмч өмчтэй байгаад солилцоонд ороод, худалдаа арилжаанд ороод гээд яг энэнтэй адилхан. Хувийн эрх зүйд төр тэнд яг нөгөө хун шиг хуулийн этгээд гэдэг дээр ороод одоо эн тэнцүү солилцоонд ороод явж байгаа.

Нийтийн эрх зүйд засаглал хэрэгжүүлэгч тусдаа. Тэрийг хуулийн этгээд гэж хэрэглэж ерөөсөө болохгүй. Тэр төр өөрөө. Засаглал хэрэгжүүлэгчийнхээ хувьд миний энэ ажил хэргийн хүндэд халдлаа гээд иргэнтэй адилхан дэг нийтэдтэй болж ерөөсөө болохгүй.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя.

Х.Тэмүүжин: Ромын эрх зүйгээс улбаатай Өөлфингээс эхэлсэн нийтийн болон хувийн эрх зүйн энэ ялгааг жишээ нь Засгийн газрын санал ялгааг нь гаргаж өгөөгүй байна лээ. Тухайлбал энэ өөрөө бүүр суурь шинжтэй концепц байхгүй юу. За саяын тэр нийгэмд аюултай гээд одоо яг өөрчилж байгаа зүйл заалтуудыг та бүхэн ингээд нэг уншаад үзээрэй Эрүүгийн хуулиас нь. Нийт нийгэмд аюултай нийгмийн одоо хор уршиг гэх мэтчилэн энэ ойлголтуудаа ашиглаад тэр заачихсан байгаа зүйл заалт дээр энэ үгийг хасаад орлуулсан үгээр нь уншихаар илүү бодитой, хэмжигдэхүйц, ойлгомжтой болчхож байгаа юм. Би та бүхэнд хавсарч өгсөн шүүхийн шийдвэрүүдийн судалгаа байгаа. Шүүхийн шийдвэрүүдийн бүх судалгаан дээр хамгийн түрүүнд ингээд бүүр ингээд хэвшмэл болчихсон татаж бичиж байгаа нь энэ үг байгаад байгаа юм. Өмгөөлөгч нар шүүх хуралдаан дээрээ бас асуулт тавьсан байгаа. Кэйс одоо судалгаанууд дээр. Яагаад манай хүний хийсэн үйлдлийг нийгэмд аюултай гэж үзсэн юм бэ. Тусгай ангид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн болон тусгай ангид заасан энэ зүйл заалтаараа тийм шинж чанар ерөөсөө байхгүй байгаа шүү дээ. Эрүүгийн хуулийн ерөнхий ангид ийм үг байгаа учраас ганцхан үгтэй. Хариулт нь ерөөсөө ийм.

Тэгэхээр энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж байгаа Эрүүгийн хуулийг хэрэглэж байгаа энэ хэрэглээн дотор хэмжигдэхгүй, тодорхойгүй ийм ойлголт бичих өөрөө ер нь аюултай байна аа гэж харагдаж байгаа. Нөгөөдөх юу байна. Эрүүгийн хариуцлагын тухай ойлголт. Эрүүгийн хариуцлага гэдэг үгийг нь авчихлаа гээд Эрүүгийн хууль дээрээс албадлагын арга хэмжээ гэдэг зүйл нь алга болохгүй шүү дээ. Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа Эрүүгийн хууль дээр маш тодорхой заачихсан.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүн гүйцээгээд хариулъя. Тэмүүжин гишүүнд микрофон өгье.

Х.Тэмүүжин: Зөвхөн Эрүүгийн хууль дээр байгаа ял албадлагын арга хэмжээ гээд 2 ойлголтыг нийлүүлээд ерөнхийлөөд 1 нэр томьёо болгочихоор цаашаагаа хууль хэрэглээнийхээ хувьд их төвөгтэй байдал үүсгээд байна. 2015 оны Эрүүгийн хуулиар уг нь энийг авч хаясан юм. Тэгээд буцаагаад 2017 онд буцаад ороод ирсэн юм байна лээ. Эрүүгийн хуулиар ял хүлээгээд, ял хүлээсэн бол гээд үр дагавартай. Эрх зүйн байдал нь өөрчлөгдөхийг бол хүлээн зөвшөөрч байгаа. Эрүүгийн хуулиар ял хүлээгээгүй, албадлагын арга хэмжээ авагдчихаад, албадлагын арга хэмжээ авагдсан атал энэ эрүүгийн хариуцлага хүлээсэн гээд нөгөө өөр бусад хууль дээр эрүүгийн хариуцлага хүлээсэн бол тэгнэ гээд заалтууд ороод ирэхээр ял аваагүй. Уураа барих сургалтад суусан. Эсвэл бол одоо юу гэдэг юм. Албадлагын арга хэмжээнд байгаа олон арга хэмжээнд ингээд ямар нэгэн байдлаар орсон тэр хүн эрх зүйн байдлынхаа хувьд өөр газруудад ингээд хохироод үлдэх бололцоотой болчхож байгаа юм байна лээ.

Хоёрт нь, дахиад эрүүгийн хариуцлага гэдэг үгийн үг дотор байгаа албадлагын арга хэмжээ чинь...

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Яах вэ Тэмүүжин гишүүн ээ, та бас яах вэ хуулийн төслөө харна биз дээ. Би зүгээр анхны таны интеншн бол энэ зүгээр нийгэмд аюултай гэдэг зүйлээ хасах гээд явж байсан юм байна аа. 5 дугаар зүйл дээр чинь яг тэгээд байна. Гэтэл та буцааж оруулж ирээд 3 дугаар зүйл дээрээ 2-ыг нь хийгээд дахиад өөрчлөн найруулчихсан байгаа байхгүй юу. Нэг зүйлийг нэг хууль дээр нэг өөрчлөн найруулаад, нэг хасаад байж болохгүй шүү дээ. Тэгэнгүүтээ яг энэ хэлж байгаагийнхаа эсрэг буюу яг энэнийхээ эсрэг дахиад хор аюул гэдэг хэн ч тодорхойлоогүй Эрүүгийн хууль дээр байхгүй, дахиад үзэмжээрээ тодорхойлогддог. Хэнд гэдэг зүйл нь байхгүй ийм ойлголтыг бас ороод ирж байгаа. Би зүгээр эргэлзээд байгаа юм бас. Тэгэхээр нийгэм гэдэг зүйл дээр аливаа тэгэхээр байна шүү дээ хууль тогтоогч одоо таны энэ нийгэмд аюултай гэдэг зүйлийг аваад хаячихаар дуртай эрх зүйн эсрэг үйлдэл гэсэн энэ үйлдлүүдээ гэмт хэрэгт тооцох ямар ч хэмжээсгүй болгочхож байгаа гэдэг зүйлийн эрсдэл үүсэж байгаа.

Бид хэд яах вэ зүгээр аль ч нийгэмд эрүүгийн эрх зүй байдаг. Энэ одоо зүйлүүдийг бас хэтэрхий ингэж бас малгайлаад, энэ социалист ойлголт гэхэд бол би...

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Энэ бол нэг 10 гаруй жилийн өмнө Тэмүүжин сайд байхдаа Эрүүгийн хуулийн зарчим хөндөгдөж, ингээд талцал болоод л, идэж унаж босоод л, Цэцээр унаж босоод л тэгээд концепцын маргаан болоод л, практик хуульчид нь хуульчдын бослого болоод л, тэрэн дээр нь Тэмүүжинд дургүй улс төрчид нь нүүдэл хийгээд л, зарим нь үнэнд гүйцэгдээд л. За энийг юм дахиад үргэлжилчих вий гэсэн үүднээс би бол дэмжиж байгаа ч биш, дэмжихгүй байгаа гэдгээ ямар байр суурь илэрхийлэхгүй. Энийг илүү бид нар ийм улс төрийн хийрхэл сонирхол зүйлүүдээс хол, илүү мэргэжлийн цэврээр нь буюу шинжлэх ухааных нь үүднээс нь авч үзэх зорилгоор би нэг ийм саналтай байгаа юмаа.

Нэгдүгээрт энэ Дээд шүүхийн саналыг бид заавал авах ёстой. Прокурорын байгууллагын саналыг бол заавал авах ёстой. Бид нар Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн суурь зарчмуудыг бүгдийг нь хөндөх гэж байна. Нэгэнт Эрүүгийн хуулийн суурь зарчмуудын ерөнхий ангийн гол суурь зарчмууд хөндөгдөж байгаа бол энэ яг нэмэлт өөрчлөлт мөн үү? Энэ шинэчилсэн найруулга болно. Яагаад гэхээр энэ чинь гол суурь заалтуудыг бүгдийг нь өөрчлөөд хаячхаж байна л даа. Гэмт хэргийн шинж, хариуцлага, ял гэсэн энэ гол нөгөө суурь заалтуудынх нь онолынх нь ойлголтууд өөрчлөгдчихөөр энэ бүхэлдээ Эрүүгийн хуулийн хуулийг бид нар цоо шинээр нүдээр харах гэж байна гэсэн үг. Цоо шинэ нүдээр харах гэж байгаа бол энэ шинэчилсэн найруулга. Нэмэлт, өөрчлөлт биш.

Хоёрдугаарт, энийг бид нар Хууль зүйн байнгын хорооны гишүүд одоо Тэмүүжин маань ч улс төрч хуульч, би ч улс төрч хуульч. Бид хоёр яаж ч мэргэжлийн үүднээс шинжлэх ухаан онол яриад бид хоёрыг улс төрч л гэж харна. Өөрөөр хэлбэл улс төрчдийн гэж нөгөө гадна талдаа харагдаад байгаа юм. Тийм учраас энэ улс төрөөс нь салгаж харахын тулд мэргэжлийн хуульчдын байр суурийг эхлээд энэ хуулийн хэлэлцэх хэсгийг кноптохоос өмнө сонсмоор байна. Хэлэлцүүлэг хиймээр байна. Тал талын байр сууриудыг сонсмоор байна. Одоо миний санаж байгаагаар бол яах вэ би Нарангэрэл багш, Тэмүүжин хоёрын аль нэгийн зөв, буруу гэж ерөөсөө яриагүй. Жишээлбэл хуулийн эрүүгийн салбарын одоо хамгийн академич нь босож ирээд л юм ярьж байсан тийм ээ 10 жилийн өмнө. Энэ бол одоо тоглож байна аа. Ийм юм байдаггүй юм аа гээд. За ингэхээр Нарангэрэл багшийн үгэнд одоо хэдэн хүн итгэх вэ. Ингээд л тэрэн дээр нь яах вэ гээд...

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүн яах вэ? Энэ хариулах уу? Та их хариулах нь зөв байх аа бас.

Х.Тэмүүжин: Ер нь энэ нөгөө биднүүсийн нэг том зовлон, уламжлалт одоо ойлголтуудаасаа салж чадахгүй байгаагийн нэг л том илэрхийлэл л дээ. Орчин үед эрүүгийн хуулиар заавал нийгэмд аюултай үйлдлийг ерөөсөө хамгаалдаггүй болчихсон. Хувь хүнд аюултай үйлдлийг хамгаална, олон нийтэд аюултай үйлдлийг хамгаална. Үндсэн хуулийн дэг журамд аюултай үйлдлийг хамгаална, хүн төрөлхтний эсрэг аюултай үйлдлийг хамгаална. Түрүүн нөгөө Сайнзоригийн асуугаад байгаа хор аюул гэдэг нь тусгай анги дээрээ л заагдсан тэр объектуудаа тэр аюултай халдаж байгаа хэсгүүдээ тодорхойлж хамгаалж байгаа гэж байгаа юм. Тэрийг бүгдийг нь нийгэмд аюултай гээд урьдчилаад ерөнхий нэг гарчиг өгчихөөр хувь хүний эсрэг үйлдлүүд чинь юу юм бэ. Одоо жишээ нь яг нийгэмд аюултай гэдэг үгээр одоо шалгуур хийх гээд үзэхээр доромжлох гэдэг хоёр чинь зөвхөн хувь хүн рүү чиглэсэн үйлдэл шүү дээ ер нь бол гэх мэтчилэн.

Энэ бол бүүр шинэчилсэн найруулгын түвшний концепцын бүүр том юу ерөөсөө биш. Зүгээр нэр томъёонуудын, бараг хэрэглэгддэггүй боловч зүгээр ингээд нэг юу болоод байгаа хэлбэр дээрээ ингээд хэлбэр дүрсээ алдаад байгаа нэр томъёонуудын 3 нь засвар явж байгаа. 3 нь. Хэлэлцүүлгүүд бол хийсэн. Хэлэлцэх эсэхийг нь шийдчихээд дахиад ч хэлэлцүүлэг хийж болно. Улсын дээд шүүхээс санал ирсэн өргөн барихаас өмнө ирж амжаагүй. Улсын дээд шүүхийн санал нь энд байж байна тийм. Улсын дээд шүүхийн санал энд байж байна. Тэгээд тараах эсэхийг нь асуусан, тэгсэн чинь нэгэнт ингээд өргөн барьчихсан учраас та өөрөө эд нар өөр дээр авч бай гэсэн. Тэгээд Хууль зүйн байнгын хороон дээр юм уу, Улсын Их Хурал дээр ажлын хэсэг дээр тараачхаж болно шүү дээ энийг тийм.

Дахиад тэр эрүүгийн хариуцлага гэдэг ойлголт, ял албадлагын арга хэмжээн дээр ямар ч өөрчлөлт байхгүй. Ялын бодлого нь ч тэр, албадлагын арга хэмжээний төрөл хэлбэр нь ч тэр. Зөвхөн энэ хоёрыг нийлүүлээд ерөнхий гарчиг өгөөд байгаа нь зөв үү, буруу юу гэдэг техник хууль зүйн техникийн асуудал байхгүй юу. Энэ буруу хэрэглэж байгаа хууль зүйн техник чинь бусад хууль дээр очоод иргэний эрхийг дордуулсан, хүний эрх зүйн нөхцөл байдлыг одоо зүй бусаар хязгаарласан тийм үр дагавар үүсгээд байна аа. Эрүүгийн хуулиасаа даваад өөр хуулиуд дээр хэрэглэгдэхдээ Эрүүгийн хууль дээр ял албадлагын арга хэмжээ гээд ялыг нь ял аваагүй хүмүүс дээр очоод эрүүгийн хариуцлага хүлээсэн юм чинь гэдэг гарчигтай хүнд юм наагаад байна.

Тэгээд эрүүгийн хариуцлага гэдэгтэй холбоотой одоо тендер байна уу, одоо хуулиудаар төрийн албанд байна уу гээд маш олон зүйлүүд дээр эрүүгийн хариуцлага хүлээсэн бол эрүүгийн хариуцлага хүлээхээр бол, эрүүгийн хариуцлага хүлээхээр бол гэдэг үгийг хэрэглэх гэхээр наад дотор чинь албадлагын арга хэмжээ байгаа юм чинь энэ албадлагын арга хэмжээг хүлээхээр хүн байна шүү дээ. Урьдчилсан, одоо ийм үнэлгээнүүд орж ирээд байна. Энийг л одоо биднүүс цэгцэлж авахгүй бол одоо буруу хэрэглэгддэг, шаардлагагүй мөртөө сүүдрээрээ таагүй үр дагавар үүсгэдэг ийм нэр томъёонууд байгаад байна.

Германчууд яагаад Эрүүгийн хуулиа ялын хууль гэж хэлдэг юм. Гэмт хэргийн хууль гэж бичихгүй байна шүү дээ бүүр. Ялын хууль энэ хууль зөвхөн ялд зориулсан хууль шүү гэж. Гэтэл биднүүс Эрүүгийн хууль гэдгийг бүр ял албадлагын арга хэмжээнд зориулсан хууль болгоод эрүүгийн хариуцлага гэдэг аягүй том гарчиг өгөөд...

Д.Цогтбаатар: За гүйцээгээд хариулчих ярья.

Х.Тэмүүжин: Энэ мэтчилэн харахаар бид бол ингээд нэг жалганыхаа мухарт улс болж тоглохоос илүүтэй тэгээд тэр дундаа хүнийг шийтгэдэг, эрх зүйн байдлыг нь эрх чөлөөг нь хязгаарлаж, эрх зүйн байдлыг нь доош нь нийгмийн статус дээр нь буулгадаг энэ хуулийг бас нэг олон улсын түвшинд, дэлхий нийтийн ололт тэр хүрээнд нь бас эргэцүүлж харах цаг болчихсон. Алийн болгон одоо ингээд байгаа хуулийнхаа хэмжээнд одоо сэтгээд тэрийгээ шинжлэх ухаан гэж бодож явах вэ дээ. Би одоо дахиад нэг кэйс. Суурийн Жанцан гээд манай эрүүгийн эрх зүйн нэг том төлөөлөгч байсан юм. Эрүүгийн хуулиудад хуулийн тухай хэлэлцүүлэг дээр ирээд бүх юман дээр би бараг 40 хэдэн асуулт асуусан тэр хүн. Асуусан асуучаад нэг үг хэлсэн. За багш нь хурдхан явж номоо заръя гэсэн. Яасан гээд тэгсэн чинь энэ хууль гарах юм бол миний ном зарагдахгүй юм байна аа гэж. Өөрөөр хэлбэл тэр үедээ хүлээн зөвшөөрсөн мэдлэг үнэ...

Д.Цогтбаатар: За тэгвэл тийм тэлье тэлье. Хэдүүлээ тийм. Яах вэ одоо тэгэхлээр ингэе. Би санал хураалгалгүй хойшлуулчихъя. Тэгээд дараагийн хурал дээр оруулж ирье. Бүлэг дээр наад юугаа асуудлаа ярья гэж байгаа бол би бас тэрийг боломжийг олгоё гэж бодож байна. Үгүй ээ үгүй. Тэгэхдээ л яриг тийм. Үгүй тэгэхдээ яах вэ яриадхаг тийм. Энэ удаа тэгэхдээ би ингээд хойшлуулъя. Яагаад гэвэл энэ дээр нээрээ бас ярих асуудлууд байна аа.

Дараагийнхаа ажил руу оръё. Саяын юуг бол ойлгочихлоо. Яг хэлж ярих юмнууд байна байна.

За 3 дугаар асуудал. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье ээ.

Тогтоолын төслийг тараасан байгаа юу. Хүмүүсийн нэр нь байхгүй байгаа байх. Тэгэхдээ одоо хэдүүлээ тэрийг ярьчихна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Хүн байхгүй байна.

Тэгэхлээр тогтоолын төсөл дээр яг энд 3 гишүүн Уянгахишиг гишүүнээр ахлуулаад, Баасанжаргал гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүнийг оруулаад ийм ажлын хэсэг байгуулъя аа гэсэн ийм санал байгаа юмаа.

Тэгээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Үг хэлэх гишүүд байна уу? Тэмүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүжин: Одоо ингээд Хүний Эрхийн Үндэсний Комиссын илтгэлд дурдагдаад ингээд ирэхээр хамгийн их ноцтой зөрчлүүд гарч байгаа хэсэг дээр чинь ингээд мөрдөн шалгах үйл ажиллагаа байна аа. Тэр дундаа нууц мөрдөн шалгах ажиллагаа, гүйцэтгэх ажил, тэр чиглэлийн юм чинь ингээд хэтэрхий одоо хил хязгааргүй, хууль дүрэмд баригддаггүй, ардаа дандаа эрүү шүүлтийн элемент агуулсан тийм болоод хувирчихлаа. Тэгээд ийм байгаа нөхцөлд одоо энэ тогтоолын Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээрээ бас биднүүс нэг 3, 4 юмыг шийдмээр байна аа.

Нэгдүгээрт, ер нь энэ эрүү шүүлттэй холбоотой асуудал дээр дагнасан мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллага байгуулах юм уу, үгүй юм уу. Энэ чиг үүргээ хэнд харьяалуулах юм гэх мэтчилэн юмаа яримаар байна нэг. Хоёрт нь энэ эрүү шүүлттэй холбоотой шүгэл хүлээж байгаа хохирсон иргэд эрхээ хамгаалах гэж байгаатай холбоотой. Энэ гэрч хохирогчийг хамгаалах тогтолцоогоо одоо сэргээх юм уу, үгүй юм уу. Энэ тухайгаа яримаар байна. Гэрч хохирогч чинь бол ний нуугүй хэлэхэд хамгаалалтгүй байна. Тэр дундаа ингээд мөрдөн шалгадаг гэмт хэрэгтэй тэмцдэг байгууллагаас бол бүүр хамгаалалтгүй байна. Гуравт нь энэ хохирол барагдуулахтай холбоотой асуудлыг нь шийдэхгүй бол хамгийн их хохирлоо барагдуулж чаддаггүй хохирсноороо үлддэг хүмүүс чинь энэ чиглэлийн хүмүүс байна. Дандаа гэмт хэрэгтэй тэмцдэг мөрдөн шалгадаг байгууллагын үйл ажиллагаанд өртөөд түрүүгээрээ хохирлоо барагдуулж чаддаггүй. Яагаад гэвэл хохирсон гэж хэлээд гомдол санал гаргах юм бол илүү их хатуурхах байх. Эсвэл илүү одоо өширхөөд бүүр хачин юм болж магадгүй гэдэг айдастайгаа үлдээд байна аа. Энэ хохирол барагдуулах хамгаалалтын системээ яах юм. Тэрийг л шийдмээр байна.

Дөрөвт нь, дахиад ер нь бол одоо энэ эрүү шүүлт, энэ нууц мөрдөн шалгах үйл ажиллагааны ард ингээд эрүү шүүлт чинь ингээд хавтгайраад байна гэж байгаа бол энэ гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг одоо яах юм. Энэ завсар дундын, салбар дундын байдлаар одоо ингээд яг үнэндээ парализ болгоод яваад байгаа энэ хуулиа өөрчлөөд энэ гүйцэтгэх ажлын мөрдөн шалгах чиг үүрэгтэй байгаа байгууллагуудынхаа мөрддөг хийдэг гүйцэтгэх ажлуудыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль болон Хууль сахиулах ажиллагааны хууль руугаа оруулмаар байна. Тэр хуулиа гаргамаар байна. Тагнуулын үйл ажиллагаагаа тусдаа хуультай болгомоор байна. Тэгж салгаж авахгүй бол ил одоо шүүх рүү явдаггүй

байгууллагын одоо хуулийг нааж хийснээсээ болоод шүүхийн хяналтаас гадуур гүйцэтгэх ажил чинь бүүр гаарлаа. За төгсгөлд нь 5-д нь энэ парламентын хяналтаа яах юм, яаж оновчлох юм. Энэ хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх ял эдлүүлэх үйл ажиллагаанд явагдаж байгаа нууц мөрдөн шалгах болон гүйцэтгэх ажлууд чинь хүний эрх талаасаа хянагдахгүй байна. Хууль дээдэлдэг улсынхаа зарчмаар явахгүй байна.

Тийм учраас одоо парламентынхаа хяналтыг яаж оновчлох юм. Тусгай хяналтаа яаж сайжруулах юм. Нэг бол Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд энэ эрх асуудлынхаа хүрээнд тусгай хяналт хиймээр байна. Хэрвээ тусгай хяналт Хууль зүйн байнгын хороонд байж болохгүй гэвэл Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд биш Улсын Их Хурлын эрхлэх асуудал өөрөө Тусгай хяналтын дэд хороогоо томруулмаар байна. Хувилбаруудаа сонгож хийхгүй бол энэ чинь Байнгын хорооны эрхлэх асуудлаас зөрчилдөөд ажилладаггүй тусгай хяналт болчхоод байна шүү дээ. Энийгээ яах юм.

Ийм асуудлуудыг шийдэх хэмжээнд Улсын Их Хурлын тогтоолын гарахгүй юм бол дахиад өмнө гаргадаг тогтоолууд болчхоод хувирна шүү. Хоёрт нь, өмнө гаргасан тогтоолоо нэхэж чаддаг Улсын их Хурал баймаар байна. Жишээ нь өнөөдөр орж ирсэн асуудал ч тэр шүү дээ тиймээ. Өмнө нь гаргасан тогтоолын чинь дагуу Засгийн газар дутуу ажиллаад ороод ирэхээр дутуу ажилласан зүйлийг нь Улсын Их Хурал нөхөж ч болох юм уу, болохгүй юм уу. Эрүү шүүлт тулгасан нотлох баримт, эрүү шүүлт тулгагдсан гэрчийн эх үүсвэрийн асуудлыг чинь бид шийднэ гэж өөрсдөө тогтоол гаргачхаад, Засгийн газар дутуу оруулаад ирэхээр бид Засгийн газар оруулж ирсэн хэмжээнээс хальж...

Д.Цогтбаатар: Зөв зөв. Саяын энэ юмнуудтай бол санал нэг байна аа. Тийм учраас харин одоо энэ тогтоолыг гаргахад ажлын хэсэг саяын хэлж байгаа юмнуудыг анхаарч өөрөөр хэлбэл бас нэлээн одоохон манайхан тийм. Энэ чинь ажлын хэсэг харин боловсруулах байхгүй юу. Ажлын хэсгийг л би боловсруулах ажлын хэсэг байгуулах гээд байгаа юм. Уянгахишиг тийм. Тэгээд ор ор болно шүү дээ. Үгүй ээ үгүй. Тэгвэл болно болно. Ахлах хүн тэгвэл Энхбаярт яах вэ энэ дээр би бол Уянгахишиг гишүүнийг, Уянгахишиг гишүүн за гэсэн. Хэрэв та ахалъя гэж байгаа бол би тийм санал оруулж болж байна. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Дарга аа юу байгаад байгаа юмаа. Нөгөө Хүний Эрхийн Үндэсний Комиссын одоо тодорхой энэ жилийн тайлангийн сэдэв бол бас тодорхой сэдвүүд байсан шүү дээ. 6 бүлэг сэдэв байлуу тиймээ. Тэгэхээр би бол яг бас нэлээн асуудлуудаа бас бодитой харах ч гэдэг юм уу, гишүүд оролцоод явах нь зөв байх. Тэгэхдээ Тэмүүжин гишүүний хэлж байгаа зүйлүүдийг би ерөөсөө агуулгын хувьд бол буруу гэж байгаа юм биш шүү. Гол нь Хүний Эрхийн Үндэсний Комиссын энэ жилийн илтгэлийн сэдвийн хүрээнд бид нар энэ ажлын хэсэг ажиллах ёстой юм байгаа юм. Хаа хамаагүй бүх зүйлийг биш. Энэ Хүний Эрхийн Үндэсний Комиссын хуулийг хийж байхдаа тэгсэн байхгүй юу. Байнгын хороон дээр сонсоод хаячихдаг байсныг Улсын Их Хурал руу ороод сонсдог, бүгд мэдээллээ авдаг. Хүний эрхийн асуудал чинь зөвхөн Хууль зүйн байнгын хорооны асуудал биш бүх чуулганаараа хэлэлцчихээд.

Тэгэхээр яг энэ жилийн 24 дүгээр илтгэл за би одоо нөгөө юугаа тоогоо андуурч магадгүй. Энэ илтгэл дээр дурдсан сэдвийн хүрээн дээр Засгийн газартаа

ямар чиглэл өгч, ямар чиглэл нь хууль эрх зүйг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын чиглэлээр, соён гэгээрүүлэх чиглэлээр ч гэдэг юм уу ийм юмаар юу хийх вэ гэдэг л Улсын Их Хурлын тогтоол орж ирэх гэж байгаа. Тэгэхээр одоо энэ дээр Цогтбаатар дарга сая юу гэхээр Тэмүүжин гишүүний юмыг анхаарчхаарай гэхээр дараа нь нөгөө магадгүй би зүгээр Тэмүүжин гишүүн ээ, зарим нөгөө юмнуудыг чинь тогтоож авсангүй. Энэ комиссын илтгэлийн хүрээнд энэ ажлын хэсэг маань энэ удаад орж ирээрэй л гэж. Тогтоол гарсан байхгүй юу Тэмүүжин гишүүн ээ. За яах вэ заримыг нь хэдүүлээ тэрийг яг ингээд дэгээрээ л яваасай л гэх хүсэлт байгаа шүү.

Д.Цогтбаатар: Тийм. Гол энэ ийм байгаа юм. Тэмүүжин гишүүн ээ бас гарсан тогтоолууд бол алхам алхмаараа хэрэгжээд, тэндээс нь юмнууд явж байгаа шүү. Бүүр ингээд хаягдчихсан юм бол байхгүй. Харин гүйцэд орж ирэхгүй байгаа, засагт өгчихсөн үүрэг нээрээ гүйцэд орж ирэхгүй. Ялангуяа өмгөөллийн хууль эд нартай бол нэхэж байж оруулж ирж байгаа юмнууд бас байгаа. Тэгэхдээ бид нар нэхэх л ёстой юм чинь тэгээд л оруулж ирээд л явна шүү дээ тийм.

Тийм учраас би хэлээд байна шүү дээ. Бүүр ингээд орхигдсон юм бол байхгүй шүү. Харин бүрэн жигд бүгдээрээ орж ирэхгүй байгаа. Тэгэхлээр нь бид нар шахаж байгаад оруулж ирж байгаа юмнууд бол байгаа. Одоо нэг тогтоол дээр дурдаад оруулж ирэхгүй байхад дараагийн тогтоол дээрээ дурдаж байгаад оруулж ирж байгаа юмнууд байгаа. Тийм учраас ажил бол ингээд явахгүй байгаа гэж бол ярьж болохгүй ээ. Харин бүрэн гүйцэт одоо ханасан хэмжээнд явахгүй байгаа бол хэдүүлээ шахаад л хийгээд явъя.

Тэгээд энэ ажлынхаа хэсгийн юу юуг тэгвэл шинэ би бүрэлдэхүүнээр танилцуулаадахъя. Ажлын хэсгийн даргыг Энхбаяр даргаар гишүүнээр, тэгээд Тэмүүжин гишүүн оръё гэсэн. Саналаараа гишүүд орж болно. Алтанхуяг гишүүн оръё гэсэн, Даваагийн Цогтбаатар оръё. Даваагийн Цогтбаатар гишүүн тэгвэл хасагдлаа. Тэгээд оронд нь Сайнзориг гишүүн орчихъё, Уянгахишиг гишүүн орсон байгаа. Эрдэнэболд гишүүн өөрөө байхгүй байна шүү дээ одоо. Үгүй ээ тийм. Тэгэхдээ өөрөө байхгүй байгаа болохлоор хэдүүлээ юу яачихъя.

Ингээд ахиад би уншаад танилцуулаадахъя. Энхбаяр гишүүн дарга нь, Тэмүүжин гишүүн, Алтанхуяг гишүүн, Уянгахишиг гишүүн, Сайнзориг гишүүн гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийг байгууллаа.

Ингээд энүүгээр санал хураалт. Дэмжье гэсэн томьёоллоор.

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Ажлын хэсэг байгуулагдлаа. Ажилдаа орцгоогоорой. Байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал хэлэлцэгдэж дууссан тул Байнгын хорооны хуралдаан өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ